

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС АГЕНТЛАГ, СУМДЫН
2017 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2017.11.04

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаан 10-р сарын 27-нд болж 5 асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, аймгийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийг тус тус хэлэлцэн баталж, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “в”, 29 дүгээр зүйлийн 29.1.1 “д” заалтууд хүчингүй болсонтой холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 47 дугаар тогтоолоор байгуулсан “Аймаг хөгжүүлэх сан”-г татан буулгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Мөн Монгол Улсын Тариалангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.4 дэх заалт, “Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослон эрхлэх стратегийн бүс нутаг болгон хөгжүүлэх” онол үйлдвэрлэлийн олон улсын бага хурлаас гарсан зөвлөмж, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг үндэслэн “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийг эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослон эрхлэх стратегийн бүс нутаг” болгох саналыг ХХААХҮЯ-нд уламжлахаар шийдвэрлэсэн.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид 10-р сард 3 удаа хуралдаж 14 асуудал хэлэлцэж, 11 тогтоолыг гаргасан. Үүнд:

-Аймгийн ИТХ-ын ээлжит 6-р хуралдааны товыг тогтоож, Мандал сум дахь Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм, сумын ИТХ, Засаг даргаас ирүүлсэн саналыг үндэслэн Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 148 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу Мандал суманд үйл ажиллагаа явуулж буй Христийн шашны “Хожмын үеийн гэгээнтнүүд”-ийн сүмийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар сунгав.

-Төрийн захиргаа, эрүүл мэнд, төмөр зам, хөдөө аж ахуй, газар тариалан, хууль хяналтын байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан Сэлэнгэ аймгийн харьяат зарим иргэдийг Монгол Улсын цол, одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлан материалыг хүргүүлэв. Үүнд: МУ-ын Гавьяат цолоор 2, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 6, Алтан гадас одонгоор 14, Цэргийн гавьяаны одонгоор 1, Хөдөлмөрийн хүндэт медалиар 19, цэргийн хүндэт медалиар 1 иргэнийг тус тус шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид материалыг уламжлан хүргүүллээ.

-Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг тохиолдуулан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан зарим хүмүүсийг “Нутгийн шилдэг удирдагч” шагналаар шагнуулахаар материалыг хүргүүллээ.

-Дэлхийн болон Монголын багш нарын өдөр, ахмадын өдөр, нутгийн удирдлагын 25 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг Сэлэнгэ аймгийн хүндэт тэмдэг, аймгийн ИТХ-ын Хүндэт өргөмжлөлөөр шагнав. Хүндэт тэмдгээр 6, хүндэт өргөмжлөлөөр 13 иргэнийг шагналаа.

10 дугаар сарын 31-ний өдөр хуралдсан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар аймгийн ИТХ-ын ээлжит 7-р хуралдааны товыг тогтоож хэлэлцэх асуудлуудыг баталсан.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн хэмжээнд “Соёлтой харилцаа-шуурхай үйлчилгээ” хөдөлгөөнийг энэ сарын 25-ны өдрөөс, “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон” аяныг мөн энэ 10-р сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 тоот албан даалгаврыг сумдын Засаг дарга, газар, хэлтэс албадын дарга нарт хүргүүлж, хэрэгжүүлж ажиллах талаар үүрэг чиглэлийг өгөөд байна.

2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганд дэлхийн 193 орны удирдагчид оролцон баталсан "Тогтвортой хөгжил-2030" хөтөлбөрийн тунхаглал, тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг хэрэгжүүлэх, эдгээр зорилтуудыг ирээдүйд хэрэгжүүлэх үндсэн хүч болсон хойч үеийнхэнд сурталчлан таниулах үүднээс “Тогтвортой хөгжлийн боловсрол” (ТХБ) төслөөс Сэлэнгэ аймгийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд аймгийн төвийн дунд сургуулийн сурагчдын дунд тогтвортой хөгжил, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн зорилтуудыг сурталчилан Сэлэнгэ аймаг 2030 онд хэрхэн хөгжиж, тогтвортой хөгжлийн зорилтуудад ямар хувь нэмрээ оруулж болохыг дунд сургуулийн сурагчид хэрхэн төсөөлж буйтай танилцахыг зорьж 2 сарын хугацаатай төслийн уралдааныг аймгийн төв Сүхбаатар сумын 7 сургуулийн дунд зарлан 10-р сарын 28-ны өдөр төслийн уралдааны шалгаруулалт болсон. Уралдаанд Сүхбаатар сумын улсын тэргүүний 4 дүгээр сургууль тэргүүн байр эзэлж, улсын тэргүүний 2 дугаар сургууль, ерөнхий боловсролын 3 дугаар сургууль удаах байрт шалгарлаа.

Монгол Улсын Удирдлагын академийн Төрийн захиргааны менежмент, Бизнесийн удирдлагаар мэргэшүүлэх дипломын сургалтын талаарх мэдээллийг аймгийн цахим хуудас болон, Фасебүүк хуудас, Миний Монгол ТВ, Таны Сэлэнгэ ТВ-ээр дамжуулан иргэдэд хүргэж, шалгалтыг 2017 оны 10 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулан, Засгийн газрын тэтгэлгээр 1 иргэн, хувийн зардлаар 2 иргэн суралцахаар болсон. Мөн Удирдлагын академид Төрийн захиргааны менежментээр Магистрын зэрэг олгох улирлын сургалтанд элсэх хүсэлт гаргасан 2 төрийн албан хаагчийн материалыг хүлээн авч удирдлагын академид хүргүүлснээр Засгийн газрын тэтгэлгээр мөн 2 иргэн суралцахаар болсон.

Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Орхон, Хөвсгөл аймгуудыг оролцуулсан “Харилцаа холбооны хөгжил-2017” бүсийн зөвлөгөөн тус аймгийн төв Сүхбаатар суманд 10-р сарын 04, 05-ны өдрүүдэд болж, салбарын эрх зүйн орчин, өнөөгийн байдал, Харилцаа холбооны салбарын бодлого, зохицуулалт, Харилцаа холбооны салбарын чиг хандлага, Харилцаа холбооны салбар орон нутагт сэдвүүдээр мэдээлэл өгч, харилцан асуулт хариулт өрнүүллээ. Зөвлөгөөнд дээрх таван аймгийн нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг явуулж байгаа цахилгаан холбоо, радио телевиз, шуудан, мэдээллийн технологийн салбарын 140 гаруй төлөөлөл хамрагдлаа.

ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрийн 2017-2020 он хүртэл хэрэгжих “Тогтвортой аялал жуулчлал-Түншлэлийн үнэ цэнэ” төсөл буюу 3-р үе шат эхэлж байгаатай холбогдуулж Улаанбаатар хотноо 2017 оны 10-р сарын 03-04-ны өдрүүдэд зохион байгуулагдсан төлөвлөлтийн хуралд тус аймгийг төлөөлж аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон төслийн ажилтан нар хамрагдлаа.

Энэ онд аймгийн хэмжээнд нийтдээ 203.1 мянган га талбайд тариалалт хийсэн. Ургац хураалтын эцсийн мэдээгээр нийт 157,7 мянган га үр тарианы талбайгаас 148,1 мянган тонн буюу нэгж га-гаас 11,1 цн ургац хураан авсан. Үүнээс улаанбуудай 150,1 мянган га-д тариалж, 144,3 мянган тонн буюу нэгж га-гаас 11,3 цн, тэжээлийн ургамал 11,1 мянган га-гаас 13,7 мянган тонн, тосны ургамал 35,2 мянган га-гаас 8,9 мянган тонн, төмс 2572 га-гаас 27,7 мянган тонн, хүнсний ногоо 2539,1 га-гаас 29,1 мянган тонныг тус тус хураан аваад байна.

Энэ зуны цаг агаарын хэт халалтын улмаас үр тарианы 21,4 мянган га, таримал тэжээлийн 2,0 мянган га, тосны ургамлын 12,6 мянган га, төмс, хүнсний ногооны 246,4 га талбайн ургац алдсан байна.

Аймгийн хэмжээнд 29950 тн багтаамжтай 3034 ширхэг төмс, хүнсний ногооны зоорийг ариутгаж 8 нэр төрлийн 29,9 мянган тн төмс, хүнсний ногоог хадгалж, аж ахуйн нэгжүүд ирэх хаврын тариалалтанд 17,0 мянган тн үр нөөцлөөд байна.

2017 оны 10 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд “Ногоочдын зөвөлгөөн”, “Сэлэнгийн ногоон өдрүүд 2017” үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Тус зөвлөгөөний үеэр Сүхбаатарын талбайд “Сэлэнгийн ногоон өдрүүд 2017” шинэ ургацын төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаанд 16 сумын 50 ногоочид 40 нэр төрлийн төмс, хүнсний ногоотой оролцож, 13 сая төгрөгний борлуулт хийсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын “Хөдөө аж ахуйн салбарын 2017 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай” 186 дугаар тогтоол, “Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 187-р тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын албан даалгаврыг гаргасан.

2017 онд аймгийн хэмжээнд 17 сумын 56 багт 8558 малчин болон мал бүхий өрхөд 1,6 сая толгой мал өвөлжихөөр зохион байгуулалтын арга хэмжээг аваад байна. Малчид зун, намрын улиралд хол ойрын оторт гарч мал сүрэгтээ тарга хүч авахуулах ажлыг зохион байгуулснаар мал сүргийн 85 хувь нь дунд ба дундаас дээш тарга хүч аваад байна. Одоо ихэнхи малчид орон нутагтаа өвөлжиж, хаваржихаар бэлтгэл ажлаа базааж байгаа бөгөөд 14,1 мянган толгой мал бүхий 51 өрх нь Хэнтий, Дундговь, Төв, Сүхбаатар аймгийн сумдад, 19,3 мянган толгой мал бүхий 99 өрх нь аймаг дотроо буюу Зүүнбүрэн, Шаамар, Цагааннуур, Хушаат, Ерөө, Хүдэр, Түшиг сумын нутагт өвөлжихөөр бэлтгэл ажлаа хангасан. Мөн тус аймагт Дархан-Уул, Төв, Орхон аймгийн 6.5 мянган мал бүхий 12 өрх Ерөө, Жавхлант, Түшиг, Орхонтуул, Зүүнбүрэн, Хушаат сумын нутагт өвөлжихөөр нүүдэллэн ирээд байна.

Аймгийн хэмжээгээр 121,2 тн үй аай ой ааеааеёеёи бааёаи, 24,2 мянган тн хүчит тэжээл, 4,8 мянган тн эрдэс тэжээл бэлтгэхээс 111,2 мянган тн өвс, 10,2 тн үй аай ой нждүйе, 9,4 тн үй аай ой ии аи иу ауйе, 15,9 тн үй аай ой зееаауеёеи ууауйе, 6,1 мянган тн дарш, 3,7 мян.тн эрдэс тэжээл, 3,6 мян.ой ааё ууауйе ауйеоаусэн нь мал бүхий иргэдийн түвшинд бэлтгэх өвс, тэжээлийн 98%-ийг бэлтгэсэн.

Аеи аеи өвс, тэжээлийн аюулгүйн иоооа 150 тн өвс, 30 тн тэжээл бэлтгэхээс 100 ой өвс, 15 оц-её ууауйе бэлтгэсэн нь 58,3%, нои уи иоооа 1700 тн өвс, 510 тн тэжээл бэлтгэхээс 1100 ой оас, 223 тн тэжээл бэлтгэсэн нь 54,2%-тай ааеи а.

Тэжээлийн нэгжид өеёаааеёи ууё аеи аеи оyi ауйауйё 77203955 тэжээлийн нэгж бүхий ууауйе ауйеууи иу иуаои иеи ой еа еа 23,7 т.нэгж ии ааи аааеи а. Энэ нь нийт малыг 40-50 хоног нэмэгдэл тэжээлээр тэжээхэд хүрэлцэхүйц нөөц юм.

Yiy iia aeii aeii oyi ауйауйё 48,2 тн үй ган толгой хонь, 7,4 мянган толгой тол ямаа, нийт 55,6 мянган толгой бог малд зсёуа аи аеёаёоёеёаа 17 сумын 10,9 мянган толгой хээлтүүлэгч малд үзлэг, аттестатчилал явуулж, үржлийн шаардлага хангасан 9,2 мянган толгой хээлтүүлэгч малыг баталгаажуулж, шинээр 1090 хээлтүүлэгч нөхөн тавьснаар хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо хэвийн хэмжээнд ойртож байна.

Иеёо малчин, иаё аюеёе орхийн бэлтгэл хангалт 89,7 боайтай ааегаа боловч аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт хангалтгүй байгаагаас аймгийн нэгдсэн дүнгээр 73 хувьтай өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангасан дүнтэй гарлаа.

Малын амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 638.0 мянган толгой мал хамрагдахаас технологит хугацааг баримтлан 635.8 мянган толгой мал, амьтан, гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд нийт 869.4 мянган толгой хонин сүрэг, бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 35.7 мянган толгой тугал, 368.6 мянган толгой богийн төлийг

вакцинжуулалтанд хамруулж, Паразиттах өвчнөөс урьдчилан болон эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 2058.2 мянган толгой мал, амьтан хамруулахаас 2045.2 мянган толгой мал, амьтан буюу үүнээс угаалганд 1368.1 толгой мал, амьтан, туулгалтанд 272.7 мянган толгой мал, амьтан, боловсруултанд 404.4 мянган толгой мал, амьтан тус тус хамруулсан байна. Бусад аймаг, орон нутгаас орж ирж буй мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлан ариутгал халдваргүйтгэлийн цэгүүдийг Дулаанхаан, Баянгол, Жавхлант сумдын автозамын болон байгаль орчны хяналтын цэгүүдийг түшиглэн халдваргүйжүүлэлтийн цэгүүдийг орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан ажиллуулж байна.

Төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК нь 2017 онд их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын 108 ажлыг 8.2 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс өнөөдрийн байдлаар 99 ажлыг бүрэн хийж ажлын гүйцэтгэлийг 92 хувьтай байна. Мөн Түнхэл тосгоны 35/10кВ-ын дэд станцын шинэчлэлтийн ажил, 35 кВ-ын 8 км агаарын шугамын ажил, Мандал, Алтанбулаг, Цагааннуур, Сайхан, Хүдэр сумдын 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэлтийн ажлын хүрээнд 27 дэд станцын 41.5 км агаарын шугамыг шинэчлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн төвийг дулаанаар хангагч “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын дулааны станц нь өвөлжилтийн бэлтгэлийн бүрэн хангасан, өнөөдрийн байдлаар 6000 тонн нүүрсний нөөцтэй. Сумдын халаалтын зуухны урсгал болон их засварын ажлууд хийгдэж, дулаан хангамж жигдэрсэн, 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 7-120 хоногийн буюу 10493 тонн нүүрсний нөөцтэй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл болон аймгийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийг тайланг аймгийн ИТХ-ын ээлжит хурлаар энэ сарын 27-ны өдөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

2017 оны 3-р улирлын байдлаар аймгийн хэмжээнд 11596 өргөдөл гомдол ирснээс 10771 өргөдөл гомдолд хариу өгч, 141 өргөдөл гомдлыг бусад байгууллагад шилжүүлж, 684 өргөдөл гомдлын хугацаа болоогүй байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 92,8 хувьтай байна. Монгол Улсын Засгийн газрын 1111 утсанд энэ оны 9-р сарын байдлаар Сэлэнгэ аймагт хамааралтай 41 өргөдөл, гомдол гаргаснаас 23 өргөдлийг хуулийн хүрээнд шийдвэрлэж, 56,1 хувьтай байна.

Онцгой байдлын талаар:

ОБЕГ-аас ирүүлсэн үүргүүдийн хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд хүргүүлэн ажиллалаа. Тайлант сард “Үүрэг хүргүүлэх тухай” 2/1891 дүгээр албан үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын тамгын газраас Төв, Дархан-Уул аймгийн Засаг даргад өвөлжилтийн бэлтгэл ажил, үүсч болзошгүй нөхцөл байдалд хамтран ажиллах талаар албан бичиг хүргүүлж, албан үүргийн биелэлтийг цахимаар болон цаасаар хүргүүлсэн. Мөн аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд цацраг идэвхит бодис ашиглаж байгаа талаарх мэдээлэл, “Өсвөрийн аврагч-2017” тэмцээний илтгэх хуудсыг, “Цэргийн алба хаагчдын бие бялдрын стандарт”-ын “Өндөр жингийн зохистой харьцааг тодорхойлох хүснэгт”, “Бүсэлхийн зохистой харьцааг тодорхойлох хүснэгт”, “Бүсэлхийн зохистой харьцааг тооцох аргачлал”, бүсэлхий, ташааны тойргийг хэмжих аргачлал, биеийн жингийн индексийг, ахмад, залуу үеийн гурав дахь удаагийн чуулга уулзалт болохтой холбогдуулан байгууллагын түүхэн замнал, өнөөгийн үйл ажиллагаа, ирээдүйн чиг хандлагын талаарх тус чуулга уулзалтад хамрагдах алба хаагчдын илтгэлийг, албан үүргийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх, ялангуяа зөрчлийг хойшлуулашгүй шалган шийдвэрлэх ажиллагаанд гарч байгаа хүндрэл, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардлын талаар болон журам, зааврын төсөлд оруулах санал,

гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр, гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн биелэлтийн тайланг дээд газарт хүргүүлэн ажилласан.

“Хүн ам олноор цуглардаг, худалдаа, олон нийтийн байгууллагууд”-д гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах” төлөвлөгөөт шалгалтын хүрээнд 83 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 269 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 52, мэдэгдэл 12, дүгнэлт 1-ыг үйлдэж хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шаардлагыг хэрэгжүүлээгүй 2 аж ахуйн нэгж, байгууллагыг 800000 төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ ногдуулж, Мандал сумын 2 дугаар багт үйл ажиллагаа явуулдаг “Магнай трейд” ХХК-ний Мандал агуулах воганстакадын байгууламжийн тавцанг зөвшөөрөлгүй буулгасан Зөрчлийн хэргийн 1732000056 дугаартай хэрэг нээж 300.000 төгрөгийн торгууль ногдуулж захиргааны арга хэмжээ авч ажилласан.

Онцгой байдлын хэлтсийн даргын баталсан “Гэр хороолол, өвс, хадлан тэжээл” нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу Баянгол сум дахь Гал түймэр унтраах, аврах 40 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн Баянгол сум Хараа 1 дүгээр баг, Баян 2 дугаар баг, Гонир 3 дугаар багийн айл өрхүүдээр галын аюулаас урьдчилан сэргийлэх шалгалтыг зохион байгууллаа. Удирдамжит ажлын хүрээнд салааны алба хаагчид өвс хадлан тэжээл, пийшин, зуухны аюулгүй байдал, цахилгаан утасны холболтын аюулгүй байдлыг шалгаж, сэрэмжлүүлэг мэдээ, анхааруулга, санамж зөвлөгөөг хүргэлээ. Алба хаагчдад хариуцсан хорооны зам гарц усан хангамж, хүрэлцэн очих хугацаа зэрэг судалгаануудыг гаргасан. Баянгол сумын ЗДТГ-ын урсдаг самбарт тухайн арга хэмжээний талаар сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэсэн. Шалгалтаар нийт 480 айл өрх хамрагдаж 950 гаруй хүнд ухуулга яриа сэрэмжлүүлэг, гарын авлага хүргэн илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь буюу хугацаатай арилгуулахаар шийдвэрлэн, шалгалтаар ажилласан тухай фото зургаар баримтжуулан ажиллалаа. Нийт 180 гаруй зөрчлийг илрүүлэн, газар дээр нь 67 зөрчлийг арилгуулан ажилласан.

2017 оны 10 дугаар сард 7 удаагийн объектын гал түймэр гарсанаас 7 гал түймэр дээр Аврах, гал унтраах анги ажиллаж унтраасан.

Гал түймрийн шалтгаан нөхцлийг судалж үзвэл цахилгааны ашиглалтын буруугаас 2, хүүхдийн болгоомжгүй үйлдээс 2, машин техникийн гэмтэл ашиглалтын буруугаас 2 технологийн горим зөрчигдсөнөөс 1 удаа тохиолдсон.

Гал түймрийн нөхцөл байдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:

д/д	Гал түймрийн төрөл	2016 оны 10 дугаар сар	2017 оны 10 дугаар сар	Өссөн, буурсан
1	Объектын	9	7	2-оор буурсан

Ард, иргэдэд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг орон байрны гал түймэр, пийшин зуухны галын аюулгүй байдал, ой, хээрийн гал түймэр, бага насны хүүхдийн санамсар болгоомжгүй байдал, хийн түлшний галын аюулгүй байдал, цахилгаан эрчим хүчний ашиглалтын галын аюулгүй байдал зэрэг 6 сэдвээр фото цаасан дээр 400 ширхэгийг хэвлүүлж ард иргэдэд 223 ширхэгийг тарааж, “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулагдаж буй өдөрлөг”-ийн тухай Мандал сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа “Миний Монгол”, “Мандал телевиз” болон “Хараагийн мэдээ” сонин

хэвлэлээр сурталчлах, Гал түймэр унтраах, аврах техник хэрэгслийн картуудыг шинээр хийлгэж, олон нийтэд танилцуулах, Гамшгийн эрсдлийг бууруулах олон улсын өдрийн хүрээнд зохион байгуулсан ажлуудыг ОБГ-ын цахим хуудсанд байршуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мандал суманд үйл ажиллагаагаа явуулдаг хуулийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 19 дүгээр анги, сум дундын Цагдаагийн хэлтэс, Шүүх, Поркурорын газар зэрэг байгууллагууд оролцлоо. Өдөрлөгийн үеэр Онцгой байдлын албаны үйл ажиллагаа, чиг үүрэг, Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хуулиудыг иргэд олон нийтэд сурталчилан таниулах, Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах 19 дүгээр ангид ашиглагдаж буй шуурхай албаны болон гал унтраах зориулалт бүхий автомашин, техник хэрэгсэл, завь, хорт хий утаанаас хамгаалах баг, аврах багаж хэрэгсэл, холбоо зохион байгуулалтын радио станцын талаархи мэдээллийг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд сурталчилан хүргэлээ. Өдөрлөгийн арга хэмжээнд оролцсон иргэдэд Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж, гарын авлага зэрэг 300 ширхэг материалыг тараалаа.

Гамшгийн эрсдлийг бууруулах олон улсын өдрийн хүрээнд Баянгол сум дахь гал түймэр унтраах, аврах 40 дүгээр анги, ДЗОУБ-ын Зүүн хараа орон нутгийн хөгжлийн төвтэй хамтран “Онцгой байдлын албаны нээлттэй хаалганы өдөр”-ийг сумын соёлын төвийн урд талбайд зохион явууллаа. Өдөрлөгийн арга хэмжээний үеэр иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулах, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн ахлах болон дунд ангийн сурагчдад гал түймрийн тухай ойлголт, урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх арга ажиллагаа сэдвээр сургалт явуулах, гал түймэр унтраах, аврах багаж хэрэгслийг танилцуулж иргэдэд багаж зэвсэглэмжийн хүчин чадлыг харуулах зэрэг сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж 150 гаруй иргэн, 120 сурагчийг хамруулан зохион байгууллаа.

Мөн Улаанбаатар Төмөр замын Сүхбаатар өртөөнд шинээр томилогдон ажиллаж байгаа ажилтан албан хаагчдад “Гал түймрийн тухай ойлголт”, “Ажлын байрны галын аюулгүй байдлыг хангах”, “Гал унтраагуураар ажиллах арга техник” зэрэг сэдвүүдээр 2 цагийн танхимын сургалтыг зохион явуулж, 15 ажилтан, албан хаагчдыг хамруулсан.

Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг “Гамшигт нэрвэгдэгсдийн тоог 2030 он гэхэд бодитойгоор бууруулах” уриан доор тэмдэглэж байгаатай холбогдуулан Сүхбаатар депогийн 38 ажилтан, албан хаагчдад “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Аюулгүй амьдрах арга ухаан” сэдэвт сургалтыг, Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 3, 4 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчид, багш, ажилчдад “Аюулгүй амьдрах арга ухаан” сэдэвт танхимын сургалтыг аймгийн Улаан Загалмайн хорооны арга зүйчтэй хамтран зохион явууллаа. Сургалтад Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 65, Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 35 багш, ажилтан, сурагчид хамрагдлаа.

Мөн өдрийн хүрээнд Сүхбаатар сумын 3 дугаар багийн иргэдийн дунд “Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлье” нэгдсэн арга хэмжээг танхимын сургалт, иргэдийн гэр орон сууцны галын аюулгүй байдлыг үзэж заавар зөвлөгөө өгөх, аж ахуйн нэгж байгууллагын галын аюулгүй байдалд үзлэг шалгалт явуулах зэрэг хэлбэрүүдээр зохион явууллаа. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан Аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх, өөртөө болон бусдад туслах мэдлэг олгох, “АНХААР аппликейшн” –ийг гар утсандаа татаж суулгах, ашиглах заавар, ашиг тусыг сурталчилсан танхимын сургалтыг тус багийн 32 иргэнийг хамруулан зохион байгуулсан. Мөн тус багийн гэр хорооллын 120 айл өрхийн пийшин, зуухны галын аюулгүй байдлыг үзэн заавар зөвлөгөө өгч тухайн багт үйл ажиллагаа явуулдаг худалдаа үйлчилгээний 6 объектын галын аюулгүй байдалд үзлэг шалгалтыг явуулах, заавар зөвлөгөө өгөх болон гудамж талбай, олон нийтийн

газраар алба хаагчид болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийн 150 ширхэг тараах материалыг ард иргэдэд тараах зэрэг үйл ажиллагааг зохион явууллаа.

Аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Мэргэжлийн анги байгуулах тухай” А/416 дугаар захирамжаар Сэлэнгэ аймгийн 17 сумд болон Гамшгаас хамгаалах алба, төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус 34 байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах тусгай зориулалтын 39-н мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулж сургалтын хөтөлбөр боловсруулан Хүдэр, Алтанбулаг сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн 86, Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй 34 байгууллагын тусгай зориулалтын мэргэжлийн ангийн 34 удирдах бүрэлдэхүүнийг хамруулан 3 цагийн сургалт зохион байгуулсан.

Аймгийн Онцгой комиссыг хуралдуулж 1 удаа Алтанбулаг сумын 64 айлын орон сууцны халаалт, засвар шинэчлэлтийн ажилд шаардагдах 52.8 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэрлэлээ.

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төвөөс хойд зүгт 3 км-т 2017 оны 10 дугаар сарын 19-ний шөнийн 01:45 цагт газар хөдлөлтийн чичирхийлэл мэдрэгдсэний дагуу Сэлэнгэ газар хөдлөлтийг бүртгэх станцын эрдэм шижилгээний 2 ажилтаны хамт Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумдын нутаг дэвсгэрт иргэдээс газар хөдөлтийн чичирхийллийн талаар санал асуулга авч голомтыг тодорхойлох ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын талаар:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд даргын 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр баталсан хөтөлбөрийн дагуу аймгийн хэмжээний харилцаа холбооны шугам сүлжээнд Монгол Улсын Харилцаа холбооны тухай, Барилгын тухай хууль болон холбогдох норм дүрэм, хэрхэн хангагдаж буй эсэхэд тандалт судалгааг 5 байгууллага аж ахуйн нэгжийг хамруулан хийж гүйцэтгэн МХЕГ-т хүргүүлсэн. Мөн автотээвэр, өргөх механизмийн хяналтын чиглэлээр Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Тогоон чулуу” ХХК, Цагдаагийн газар, “Видү” ХХК, “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ, “Сибирь транс” ХХК, Сант суманд ажиллагаа явуулж байгаа “Бошгын булаг” ХХК, Орхонтуул сумын ЗДТГ-ын эрхлэн явуулж байгаа усан замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд төлөвлөгдсөн гүйцэтгэлийн хяналт шалгалт, Сүхбаатар сумын нэр бүхий иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу “Цахим ертөнц” ХХК-ийн “Гоё” минимаркетийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж хүнсний аюулгүй байдалтай холбоотой 10 зөрчлийг илрүүлж газар нь арилгуулах арга хэмжээ авсан.

Цагааннуур суманд “Сэлэнгэ тариа” ХХК нь ХБНГУ-ын Лихтенберг (Lichtenberg) мужийн “Фирсона ЖиЭмБиЭйч (Firsona GmbH) компаниас 60 толгой үхэрт Хорио цээрийн дэглэм тогтоох тухай дүгнэлт гаргаж, “Гацуурт” ХХКомпанийн гаргасан хүсэлт, гомдлын дагуу Түшиг сумын Хэрэгчин хэмээх газарт сумын ИТХ-ын дарга өвчний голомт бүхий газар нутгаас мал их хэмжээгээр оруулж ирсэн тухай мэдээллийн дагуу хяналт шалгалтыг шуурхай зохион байгуулж Төв аймгийн Борнуур сумаас зөвшөөрөлгүй малчин ирсэн зөрчлийг илрүүлж, ххуулийн дагуу арга хэмжээ авлаа.

ТЭДС-ийн Сайхан, Сэлэнгэ салбаруудад 2017 оны ургацаас хүлээн авч байгаа хүнсний болон үрийн улаанбуудайн чанар аюулгүй байдалд хяналт тавьж 2018 оны хавар тариалах үрийн нөөцөд үрийн буудай өгөх хүсэлт гаргасан 33 аж ахуй нэгжийн үрийн улаанбуудайнаас газар дээр очиж дээж аван шинжилгээ хийж лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагчийн дүгнэлт гарган ажилласан.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмнэлгийн гаралтай хог хаягдлын утаа суурьшлийн бүсэд байнга үнэртэж байна гэсэн мэдээллийн дагуу урьдчилан

сэргийлэх хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажиллалаа.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Мэдээллийн ил тод, нэгдмэл байдлыг ханган Стандарт, хэмжил зүйн төрийн бодлого, хэлтсээс зохион байгуулж, буй арга хэмжээний талаарх шинэлэг мэдээ, мэдээллийг байгууллагын face хуудаст байршуулан, тухай бүр мэдээлж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 12 хүүхэд харах төвийн ажилтнуудад “Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540:2015” стандартын талаар сургалт хийж, аймгийн Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжилзүйн хэлтсээс хийсэн хамтарсан шалгалтын үнэлгээний дүнг танилцуулсан. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүсэлтийн дагуу Эрүүл мэндийн шинжлэх ухаан ба эмнэлгийн тусламжийн нийтлэг асуудлын стандартуудын жагсаалт, 2017 онд шинээр болон шинэчлэн батлагдсан, хүчингүй болсон стандартын талаарх мэдээллийг хүргүүлж, зөвлөмж өгч ажилласан.

Сайхан сумын “Түшиг” авто засварын газрын үйл ажиллагаанд “Авто үйлчилгээ-ангилал ерөнхий шаардлага MNS 5025:2010” стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж дүгнэлт гаргасан. Мөн Сайхан сумын 1-р багт байрлах шинээр нээгдэж буй бильярдны үйлчилгээнд “Бильярдны үйлчилгээ ерөнхий шаардлага” MNS 6001:2009 стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, холбогдох арга зүйн заавар өгч, цаашид сайн дурын баталгаажуулалтанд хамрагдаж үйлчилгээндээ тохирлын гэрчилгээ хэрэглэх тухай зөвлөгөө өглөө. Мөн Жавхлант, Сайхан, Сүхбаатар, Ерөө, Хүдэр, Хушаат, Орхонтуул, Орхон, Сант, Баруунбүрэн, Цагааннуур сум, Бугант, Номгон тосгоны 52 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ, хийж шаардлага хангасан 47 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгосон байна.

Хөвсгөл аймгийн “Хөвсгөл Мах Маркет” ХХК-ийн ОХУ-ын Буриад улс руу экспортлож буй 19 тонн адууны хөлдөөсөн маханд экспортын гэрчилгээ олгож, Сүхбаатар сумын иргэн Т.Дөлгөөний үйлдвэрлэж буй хөлдөөсөн буузыг МХГ-ын бактерлогийн лабораторид шинжилгээнд хамруулж, стандартын салбар сангаас 3 аж ахуй нэгж, байгууллага, иргэний захиалгын дагуу 6 нэрийн 6 стандартаар хангах үйлчилгээ үзүүлсэн.

Хүдэр, Ерөө, Орхонтуул, Орхон, Баруунбүрэн, Сайхан, Баянгол, Мандал, Хушаат суманд ээлжит баталгаажуулалтыг хийж, 13 шатахуун түгээх станцын шатахуун түгээгүүрийн 115 ш хэмжүүрийг шалган баталгаажуулалтад хамрууллаа. Мөн механикийн хэмжлийн төрлөөр Сүхбаатар, Сайхан, Баруунбүрэн, Орхон, Орхонтуул, Сант, Хушаат сумдын худалдаа, үйлчилгээ, төрийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 60 ш хэмжих хэрэгслийг шалган баталгаажуулалтад хамруулсан. Цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн 1 фазын 47 ш, 3 фазын 2 ш цахилгааны тоолуурыг баталгаажуулалтад хамруулсан.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэлд дотоод аудитын хяналт шалгалт хийгдлээ.

2017 оны 03 дугаар улирлын татварын тайлан хүлээн авах ажлыг зохион байгуулж, нийт 2315 аж ахуйн нэгж байгууллагаас 2200 аж ахуйн нэгж байгууллага тайлан ирүүлж 95 хувийн гүйцэтгэлтэй, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын тайлан тушаах 2556 иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 2369 иргэд, аж ахуйн нэгж байгууллага нь тайлангаа ирүүлж 92.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийн талаар аймгийн хэмжээнд 172 аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага, мэдэгдэл хүргүүлснээс 8 аж ахуйн нэгж байгууллагад хэвлэх төхөөрөмж суурилуулж ажиллалаа. Мөн тус системийн талаар 328 аж ахуйн нэгж байгууллагад сургалт зохион байгууллаа.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	15,881,649.1	16,266,934.4	102.4
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	9,859,994.4	9,002,992.3	91.3
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	58,285,051.7	51,423,431.6	88.2
	- Аймгийн төсвийн зарлагын дүн	14,088,358.5	11,680,777.6	82.9
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	477,901.0	407,122.7	85.2
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	941,578.5	202,528.9	21.5
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,626,976.1	1,053,401.5	64.7
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	1,734,023.6	1,613,648.0	93.1
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	2,750,000.0	2,750,000.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	33,016,629.8	33,016,629.8	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	17,360,207.7	17,360,207.7	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	8,462,618.2	8,462,618.2	100.0
	- Соёлын байгууллага	2,139,099.2	2,139,099.2	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	648,439.0	648,439.0	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	4,011,612.8	4,011,612.8	100.0
	- ГХБХБГазар	169,160.7	169,160.7	100.0
- ГБХЗХГазар	225,492.2	225,492.2	100.0	
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	33,016,629.8	33,016,629.8	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	17,360,207.7	17,360,207.7	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	8,462,618.2	8,462,618.2	100.0
	- Соёлын байгууллага	2,139,099.2	2,139,099.2	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	648,439.0	648,439.0	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	4,011,612.8	4,011,612.8	100.0
	- ГХБХБГазар	169,160.7	169,160.7	100.0
- ГБХЗХГазар	225,492.2	225,492.2	100.0	
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	2,601,360.9	2,606,372.3	100.2
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1390615.2	1239295.2	89.1
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	607,099.2	607,099.2	100.0
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	404,100.3	404,100.3	100.0
11	Тусгай сангуудын зарлага	1,250,074.5	301,941.6	24.2

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2017 IX- сар	2017 X- сар	2017-X 2017-IX /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА			

1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 250	1 250	
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 100	
	Нарийн боов /кг/	2 500	2 500	
	Будаа /кг/	2 300	2 200	-100
	Элсэн чихэр /кг/	2 300	2 200	-100
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 500	5 000	-1 500
	Үхрийн мах /кг/	7 000	5 500	-1 500
	Адууны мах /кг/	6 000	6 000	
	Ямааны мах /кг/	5 000	5 000	
	Дотор мах, цувдай /цусгүй/	3 000	3 000	
	Хиам /чанасан, кг/	11 000	11 000	
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	700	800	+100
	Сүү / савласан, л/	2 600	2 600	
	Тараг /задгай, л/	1 000	1 200	+200
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	1 300	
	Айраг /л/	3 500	3 500	
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	
	Өндөг /ш/	320	300	-20
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	
	Өөхөн тос /кг/	1 800	1 800	
	Шар тос /кг/	11 000	11 000	
	Масло /задгай, кг/	4 500	4 500	
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 200	1 200	
	Лууван /кг/	1 500	1 500	
	Манжин /кг/	1 500	1 500	
	Байцаа /кг/	1 500	1 500	
	Сонгино /кг/	1 500	1 500	
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	4 000	4 500	+500
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 800	2 800	
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 480	1 480	
	Бензин А - 92	1 620	1 630	+10
	Дизелийн түлш	1 720	1 720	

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.Хууль эрх зүй, цагдаа, улсын бүртгэлийн талаар:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалт буюу “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт”, “Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийг олон улсын эдийн засаг, банк санхүүгийн байгууллагаас гаргасан жагсаалт”-ыг баталсан тогтоолыг хэрэгжүүлэх талаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг сум, төр, төсвийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангах ажлыг эхлүүлсэн. “Ашиг хүртэгч жинхэнэ эздийн мэдээллийн ил тод байдал”

сэдэвт сургалтыг энэ сарын 06-ны өдөр Хууль тогтоомж, бодлого судалгааны төвтэй хамтран аймгийн төрийн захиргааны болон иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулсан.

“Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон” аяныг энэ сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 01-нийг хүртэл хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг эхлүүллээ.

Монгол Улсын Засгийн газраас Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг” төслийн хүрээнд Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн цахим сүлжээнд холбогдоогүй аймгуудын архивын хувийн хэргийн цахимжуулалтыг 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдөр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст эхлээд байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хуралд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны мэдээллийг танилцуулсан.

Аймгийн хэмжээнд 2017 оны 09 дүгээр сард 515 холбогдогчтой, 1612.2 сая төгрөгийн хохиролтой, 584 гэмт хэрэг бүртгэгдэж, 38 хэргээр буюу 7.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн гаралт Сүхбаатар сум болон 1, 2, 6, 7, 8-р баг, Алтанбулаг, Ерөө, Бугант, Зүүнбүрэн, Мандал, Баянгол, Сайхан, Орхон сумдад 3.3-84.6 хувиар, Хүдэр, Хушаат сумдад 2-3.1 дахин өсч, Сүхбаатар сумын 3, 4, 5-р баг, Шаамар, Дулаанхаан, Жавхлант, Цагааннуур, Түшиг, Сант, Баруунбүрэн сумдад 10-57.1 хувиар тус тус буурсан байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээнд 2017 оны 10 дугаар сард 216 төрөлт, 37 гэрлэлт, 18 гэрлэлт цуцлалт, 55 нас баралт бүртгэгдэж, 1168 иргэнд цахим үнэмлэх, 122 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэх 5965 ширхгийг тус тус олгож, аймаг, хотруу шилжин явсан 169, шилжин ирсэн 161, сум дүүрэгт шилжин ирсэн 95, сум дүүрэгт шилжин явсан 79, баг хооронд шилжин ирсэн 213, баг хооронд шилжин явсан 166 шилжилт хөдөлгөөн тус тус бүртгэгдээд байна. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлд 477 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 759 бүртгэл бүртгэгдэж, улсын тэмдэгтийн хураамжийн 136,583 төгрөг, үйлчилгээний хураамжийн 24,926,361 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварт 18,591,160 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

2.Архивын талаар

Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулах тухай Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/223 дугаар захирамжийн биелэлтийг хангах ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба, Сүхбаатар сумын ЗДТГ-ын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд иж бүрэн болон сэдэвчилсэн шалгалт хийж заавар зөвлөгөө өгч ажилласан. Сүхбаатар сумын ЗДТГ-тай хамтран Сүхбаатар сумын төр, төсвийн байгууллагуудын захирал, эрхлэгч нар болон архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад “Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт”, “Хадгаламжийн нэгж зохион бүрдүүлэх арга зүй” сэдэвт сургалтыг хийсэн.

Архивын салбар үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах “Архив бидний нүдээр” эссэ бичлэгийн уралдааны удирдамжийг аймгийн нийт ЕБС-дад хүргүүлэн уралдааныг зохион байгуулсан.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ салбар татан буугдаж байгаатай холбогдуулан 2004-2017 оны байнга, түр, 70 жил хадгалах 1162 хадгаламжийн нэгжийг хүлээн авсан.

Энэ сарын 20-ны өдөр “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулж, архивын сан хөмрөгөөс хосгүй үнэт баримтууд болон аймгийн 80 жилийн ойн баримт, 1960 оноос хойших Сүхбаатарын туг сонин, Аймгийн хүндэт дэвтэр, тус

аймгаас ардын хувьсгалын үйл хэрэгт оролцон тэмцэж явсан ардын хувьсгалын партизан нарын бүртгэл, жагсаалт, БНМАУ-ын санхүү нягтлан бодогч, статистикийн улсын 2-р зөвлөгөөний фото зураг нийт 35 хадгаламжийн нэгжээр үзэсгэлэн гаргаж, нийт 52 иргэн үзэн сонирхож санал бодлоо илэрхийлсэн.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2, 5-р сургуулийн байнга хадгалах баримтыг зааврын дагуу хүлээн авч нийт 73 хуудсыг скайнердаж мастер хувь үүсгэсэн. Мөн АДБ-ийн “Сэлэнгийн долгио чуулга”-ын засварын ажлын гүйцэтгэл, Баянгол сумын авто замын тэмдэг тэмдэглэгээ, гудамж талбайн гэрэлтүүлгийн угсралтын ажил, Мандал сумын Баяжуулах үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэл, Цагааннуур сумын хатуу хучилттай авто замын ажлын гүйцэтгэл, Сүхбаатар сумын доторх хайрган хучилттай авто зам талбайг асфальт бетоноор хучих ажлын гүйцэтгэл, Гэр бүлийн ордны гадна авто зогсоол, Сүхбаатар сумын Нэгдсэн эмнэлгээс 1-р сургууль хүртэлх авто замын ажил, Партизаны талбайн зам, авто зогсоол, 19,20-р байрны гадна тохижолт, зам өргөтгөсөн ажил, Сүхбаатар сумын 4-р сургуулийн спорт заалны засвар, 2-р цэцэрлэгийн их засвар, Сайхан сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, Дулаанхаан тосгоны явган хүний замын зураг төслийн баримт бичгийг хүлээн авч бүртгэл акт үйлдэн хөмрөгт байрлуулсан.

“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын хөмрөгийн 81 хадгаламжийн нэгжид ЭШТБ-ийн ажлыг хийж, сканнердаж, мастер хувь үүсгэн, үдэж хавтаслаж, архивын баримтын хадгалалт, хамгаалалтыг дээшлүүлэх ажлын хүрээнд Найрамдал сангийн аж ахуйн 1985, 1986, 1987 оны баримтуудаас нийт 1250 хуудсанд сэлбэн засалтын ажлыг хийлээ.

Иргэд албан байгууллагын хүсэлтийн дагуу цаасан болон цахим суурьтай баримтнаас архивын хуулбар 95, цалингийн тодорхойлолт 3, магадлагаа тодорхойлолт 24-ийг гаргаж үйлчилсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

2017 оны 10 дугаар сарын 04-ний өдөр аймгийн хэмжээнд “Дэлхийн багш нарын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлж, баярын хурал, урлагийн тоглолтыг зохион байгуулан, боловсролын салбарт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа багш, ажилтан, эцэг эх, төрийн болон төрийн бус байгууллагуудыг Монгол Улсын Засгийн газар, Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын яам, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Боловсрол, соёл, урлагийн газрын шагналуудаар шагнаж урамшуулсан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 1а/8372 тоот “Багшийн цалин хөлсний шинэчлэлийн тухай”, “Багшийн цалин хөлсний шинэчлэлийн бодлогын үзэл баримтлал” албан бичгийн дагуу хэлэлцүүлгийг сургууль, цэцэрлэгт зохион байгуулан санал дүгнэлтүүдийг нэгтгэн Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын яаманд хүргүүлсэн. Багш нарын цалин нэмэгдүүлэх түр хорооноос мэдэгдсэний дагуу 09 дүгээр сарын 21, 26-ны сануулах ажил хаялтад оролцох эсэх талаарх мэдээллийг авч нэгтгэхэд аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 35 сургуулийн 1700 гаруй багш, ажилтнуудаас 15 сургуулийн 688 багш, ажилтан буюу 40,4 хувь нь ажил хаялтад оролцсон бол нийт 40 цэцэрлэгийн 1000 гаруй багш, ажилтнуудаас 2 цэцэрлэгийн 52 багш, ажилтан буюу 5,2 хувь нь ажил хаялтад оролцсон байна.

“Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зүй-Багшийн ёс зүй, харилцаа” сургалтын үр дүнд мониторинг хийх, зөвлөн туслах, сургалт зохион байгуулах ажлыг 2017 оны 10 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд Сүхбаатар сумын 2, 4, 6 дугаар сургууль, Алтанбулаг сумын сургуулиуд дээр ажиллаж, багш нарын хичээлд сууж хэлэлцүүлэг хийх, багш нартай уулзаж бүлгийн ярилцлага хийх, удирдлагуудтай уулзаж ганцаарчилсан ярилцлага хийж, арга зүйн зөвлөгөө өгч сургалт зохион байгуулсан.

Аймгийн 35 сургууль, 40 цэцэрлэгийн хүүхдийг 9-10 дугаар сард цэцэрлэг 7248 сургууль 18665 нийт 25913 хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж өвчлөлийн судалгааг нэгтгэж судалгаанд үндэслэн сургууль, цэцэрлэгийн эмч нарт хүүхэд бүрийг эрүүлжүүлэх үүрэг өгөөд байна.

Аймгийн хэмжээнд 2 нийтийн номын сан, 20 соёлын төвд 1923 ширхэг номоор фондын баяжилтыг нэмэгдүүлсэн.

Сэлэнгэ нутгаас тодрон гарч дэлхийд данслагдсан агуу бөх бол “Москва-1980” олимпын наадам, “Мехико-1978” ДАШТ-ий хүрэл медальт, Дэлхийн цомын мөнгө, хүрэл медальт, Дан Коловын нэрэмжит Олон улсын тэмцээний хүрэл, Тбилисигийн Олон улсын тэмцээний мөнгөн медальт, “Интернациональ” Олон улсын тэмцээний долоо, Найрамдалт армиудын тэмцээний тав, Монгол Улсын 12 удаагийн аварга, гавьяат тамирчин Дугарсүрэнгийн Оюунболд агсан юм. Нутгийн хүчнээ алдаршуулж, их амжилтыг нь мөнхжүүлэх зорилгоор Д.Оюунболд агсны нэрэмжит 23 хүртэлх насны дэлхийн аваргын эрхийн төлөөх тэмцээнийг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд 10-р сарын 14,15-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд нийт 20 байгууллагын 184 тамирчин эрэгтэй, эмэгтэйчүүдийн тус бүр найман жинд хүчээ үзэн өрсөлдлөө.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2017 оны 09-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 917 байсан бол 225 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 217 ажлын байранд 210 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 97 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 835 болсон.

Аймаг, сумын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах зорилгоор “Алтан боломж” сургалтын төвтэй хамтран сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдийг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж нийт 30 хүн хамрагдан сертификат гардан авсан. “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай” ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын 182-р конвенц, Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/36 тоот тушаалын хэрэгжилтийг хангах чиглэлээр Баянгол, Мандал, Ерөө сум, Бугант тосгоны Бичил уурхайд хөдөлмөр эрхэлж буй эцэг эхийн гэр бүлд байгаа хүүхдүүдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 120 хүүхэд, эцэг эхийн төлөөллийг оролцуулан сургалт зохион байгуулсан.

2017 оны 9-р сарын 25-наас энэ сарын 15-ны хооронд Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд цуглуулсан мэдээллийн сангийн чанар, үнэн бодит байдлыг бүрэн хангах зорилгоор нөлөөтэй зарим үзүүлэлтийг бусад албан ёсны эх сангуудтай тулган шалгаж албан эх сурвалжаас зөрүүтэй байгаа өрхийн зарим мэдээллийн зөрүүг засварлан Өрхийн мэдээллийн нэгдсэн санд оруулж баталгаажуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мэдээлэл нь зөрүүтэй 11191 өрхийн 11057 өрхийг баталгаажуулж, шилжсэн, тухай өрх олдоогүй, татгалзсан зэрэг шалтгаанаар 134 өрхийн мэдээлэл баталгаажуагүй үлдээд байна.

Нийгмийн халамжийн сангаас 10 дугаар сарын байдлаар 28781 иргэнд 8373894543 төгрөг тэтгэвэр, тэтгэмжийг олгоод байна.

3.Эрүүл мэндийн талаар

Эрүүл мэндийн яам, Люксембургийн Засгийн газар, Монголын эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын нийгэмлэг хамтран НҮБ-ын Хүн амын сангийн “Эх нярайн тусламжид дэмжлэг үзүүлэх зайн оношлогоо”-ны төслөөс санхүүжүүлсэн “Эх барих эмэгтэйчүүдийн яаралтай тусламж”-ийн төвийн бүсийн аймгуудын эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарыг хамруулсан эрчимжүүлсэн сургалтыг зохион байгуулж Сэлэнгэ Булган, Орхон, Дархан-Уул аймгийн эх барих, эмэгтэйчүүдийн нийт 35 эмч хамрагдсан.

“Сүрьеэгүй-Сэлэнгэ” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгийн сүрьеэгийн тасаг, диспансерийн их, бага эмч, сувилагч,

лаборант, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн сүрьеэгийн асуудал хариуцсан нийт 60 мэргэжилтэнг хамруулсан сургалтыг зохион байгуулсан. Жавхлант, Цагааннуур сумын эрүүл мэндийн төвүүдийн эргэлтийн эмийн санд төлөвлөгөөт бус хяналт үнэлгээг хийж тус хяналт үнэлгээгээр гарсан зөрчил болон алдаа дутагдалыг засаж залруулах хугацаат даалгавар өгч ажиллалаа.

Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн комиссын хурлыг зохион байгуулж зөвшөөрөл хүссэн нийт 25 байгууллагын материалыг хэлэлцэж 4 байгууллагад шинээр тусгай зөвшөөрөл олгож, 2 байгууллагыг материал бүрдэлт дутуу буцаасан.

2017 оны 10-р сарын 21-22-ны өдөр 16 сум 7 тосгоны эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв болон хувийн хэвшлийн 10 багийн 150 гаруй ажилтан эмч мэргэжилтнүүдийн дунд сагсан бөмбөг, волейболын төрлөөр спортын арга хэмжээг зохион байгуулж нийлбэр дүнгээр аймгийн Эрүүл мэндийн газрын “Титэм” баг 1-р байр, аймгийн нэгдсэн эмнэлгийн “free zone” баг 2-р байр, Мандал сумын нэгдсэн эмнэлгийн “stars” баг 3-р байрыг тус тус эзэлсэн.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Алтанбулаг, Зүүнбүрэн, Сант, Баруунбүрэн, Мандал, Сайхан, Сүхбаатар сумын хүүхэд харах үйлчилгээний төвүүдэд 10 сарын мэдээгээр нийт 7 сумын 12 төвд 144 хүүхэд бүртгэгдсэнээс хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхэд байна.

“Эерэг хандлага–Эрүүл оюутан” аяныг Сүхбаатар, Шаамар сумдын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Мандал сумын Политехникийн коллежийн суралцагчдын дунд өрнүүлж, оюутан залуучуудын дунд хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг ойлгуулах, залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж 600 гаруй оюутан залуучуудыг оролцуулж, эрүүл мэндийн даатгалгүй оюутнуудыг даатгалд хамруулсан.

Өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох арга зүй эзэмшүүлэх зорилгоор “Үе тэнгийн сургагч багш бэлтгэх” сургалтыг Хүүхэд өсвөр үеийг ивээх төвтэй хамтран зохион байгуулж, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6-н сургуулийн 10 дугаар ангийн 25 сурагч оролцож багш болон үе тэнгийнхэндээ эрүүл мэндийн чиглэлээр эерэг хандлага зан үйлд суралцахад нь нөлөөлөх үйл ажиллагаанд суралцлаа.

“Залуучуудын хөгжил -2017” судалгааг 9 сум, Сүхбаатар сумын 8 багийн нийт 144 хүнээс авч нэгтгэсэн.

Яруу найрагч Г.Сэр-Одын нэрэмжит өсвөрийн яруу найрагчдын “Дунгийн эгшиг-2017” аймгийн аварга шалгаруулах уралдааныг Баянгол суманд зохион байгуулж нийт 12 сум, 3 тосгоны 37 хүүхэд оролцсон.

Олон Улсын “Охидын эрхийг хамгаалах өдөр”-ийг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж сургууль бүр охидод чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулсан. Мөн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 94 охидод нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, тэдэнд тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулан сургуулийн орчинд тулгамдсан асуудлыг сургуулийн захиргааанд шийдвэрлүүлэхээр уламжилсан.

Хүүхдийн тусламжийн утас 108-д ирсэн 8 дуудлагад хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн. Аймгийн Иргэдийн Төлөөлчдийн Хурал, “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-той хамтран өсвөр үе, хүүхэд залуучуудыг хорт зуршил, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Хар тамхи, мансуурах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн, доктор профессор Ш.Лхагвасүрэнг урьж сургалт зохион байгуулж сургалтанд Ерөнхий боловсролын 31 сургуулийн захирал, нийгмийн ажилтнууд болон сурагчдын төлөөлөл бүхий 105 хүн хамрагдсан.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар

2017 оны 10 сарын 24-ний байдлаар 21,16 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 10 дугаар сарын 24-ний

байдлаар өссөн дүнгээр 21,06 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 99,5 хувийн биелэлтэй ажиллаж байна. Тэтгэврийн даатгалын сангаас 15806 тэтгэвэр авагчдад 41115.95 сая төгрөгийг, тэтгэмжийн даатгалын сангаас 5269 хүнд 1779.00 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 292 хүнд 824.30 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 445 хүнд 589.99 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид, эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг, эмийн сангуудад 3394.29 сая төгрөгийн зардлыг тус тус олгосон. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг 46 иргэн, даатгуулагчид гарган үйлчилж, сайн дурын даатгуулагчдын тоо 2017 оны 3-р улирлын байдлаар аймгийн хэмжээнд нийт 1325-аар нэмэгдсэн байна.

Тайлант сард эрүүл мэнд, нийгмийн даатгалын тухай хуулиар 5-р сургууль, Нэгдсэн эмнэлэг, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Татварын хэлтэс гэх мэт 4 байгууллагын 225 ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

2017 оны 10 сарын 09-ны өдөр эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөх төлбөрийн чадамжгүй, эмзэг бүлгийн иргэдийг багийн Засаг дарга нартай хамтран баг тус бүрээс 5-7 иргэнийг сонгон Эрүүл мэндийн даатгалд хамрагдсны ач холбогдлын талаар сургалт зохион байгуулж дээрхи иргэдийн дунд асуулт хариултын тэмцээнийг явуулж эхний 4 байр эзэлсэн 4 даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын дэвтэрт 172800 төгрөгийн бичилт хийн нийгмийн даатгалаас санхүүжүүлэн баталгаажуулсан.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуй, байгаль орчин, хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд:

1/Хүнс, хөдөө аж ахуйн талаар

Сайхан, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Хушаат сумдад газар тариалан, мал аж ахуй, жижиг дунд үйлдвэр, худалдаа үйлчилгээний чиглэлээр хэрэгжиж буй бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, сумын Засаг дарга, хөдөө аж ахуйн тасагтай байгуулсан гурван талт хариуцлагын гэрээний төлөвлөлт, хэрэгжилтийн гүйцэтгэлд хяналт шинжилгээ дүгнэлт хийж, 2017-2018 оны өвөлжилийн бэлтгэл ажилтай газар дээр нь танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх “Зөвлөн туслах” үйлчилгээний ажлын хэсэг ажилласан.

Орхон, Ерөө, Сайхан суманд Орхон, Ерөө үүлдрийн хонинд зохиомол хээлтүүлэг хийх ажлын бэлтгэл хангасан.Монголын бэлчээр ашиглагчдын холбоотой хамтран Орхон, Орхонтуул, Баянгол, Алтанбулаг, Цагааннуур сумдад бэлчээрийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр малчдын бэлчээр ашиглагчдын хэсэг /БАХ/-ийг байгуулж, тэдэнд зориулсан 1 хоногийн сургалтыг сум бүрт амжилтай зохион байгуулсан.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3-ын “а” заалт, “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай” хуулийн 4.5 дахь заалт, мал эрүүлжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын А/368 тоот захирамжийг тус тус үндэслэн адуунаас бусад бүх мал сүргийн төл малд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд 4.9 тн мах, махан бүтээгдэхүүний 124 дээж, 2.9 тн сүү, сүүн бүтээгдэхүүний 116 дээж, 2114 өндөгний 58 дээж, 517 ш арьс ширний 53 дээж, 0.9 тн ноос, ноолуурын 29 дээжинд МЭАЦ-ийн магадлан шинжилгээ хийж баталгаажуулж гэрчилгээ олгосон.

Сүхбаатар, Мандал, зэрэг сумдаас ирсэн өвчилсөн, хорогдсон мал, амьтны 15 эмгэгт дээж, Цагааннуур сум Гацуурт ХХК-ний 103 бух, 41 үнээ, нийт 144 үхэрт

бруцеллёз өвчний шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж, үүнээс 2 бух, 1 үнээ өвчтэй гарсан.

MNS ISO/IEC 17025 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораториудын чадавхид тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу чанарын гарын авлага, журам заавруудыг дахин хянаж 3 дахь удаагаа итгэжлэгдэх бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.

2. Байгаль орчны талаар:

2017 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Тужийн нарс тусгай хамгаалалтын газарт 300 ширхэг нарс тарьсан. Мөн Жавхлант суманд цөлжилтийн эсрэг элсний нүүдлээс хамгаалсан “Ногоон Зурвас” байгуулж, Жавхлант сумын зам дагуу 5 га газарт нийт 3000 ширхэг мод тарьж хашаажуулсан.

2017 онд ойн нөхөрлөлүүдийн эзэмшлийн ойн санд гарсан түймрийн судалгаа, хохирлыг нэгтгэн гаргаж, цаашид авах арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж буй “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, ойн тогтвортой менежмент нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх” төсөлд Алтанбулаг, Баруунбүрэн, Ерөө, Мандал, Сант, Цагааннуур зэрэг сумдын 19 нөхөрлөл хамрагдсан сургалтыг Сэлэнгэ Аймгийн БОАЖГ, Онцгой Байдлын газартай хамтран 10-р сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Сургалтанд байгаль орчны улсын байцаагч, нөхөрлөлүүд нийт 67 хүн оролцсон.

Мөн “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойг гол экосистемүүдийг дасан зохицох нь” төслийн хүрээнд зохион байгуулагдсан Ойн ажилтны сургалтанд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Хессан мужийн Вайлбург хотод “Hessan Forst” сургалтын төвд 1 сар хамрагдлаа.

Ерөө, Баянгол сумдын нутаг дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар зэрэг байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж ажиллалаа.

Аймгийн Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрууд хамтран Хүдэр, Ерөө, Мандал, Баянгол, Түшиг сумын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр байгаа тусгай зөвшөөрөлтэй 24 аж ахуйн нэгжид үйл ажиллагаа явуулсан хугацааны газрын төлбөрт 28029000 төгрөг ногдуулан аймгийн төрийн санд төвлөрүүлж, зөвшөөрөлгүй нөхөн сэргээлтийн ажил хийх нэрээр олборлолт хийж байгаа 54 нөхөрлөл хувь хүмүүст хяналт шалгалт хийж, уул уурхайн эвдрэлд өртсөн талбайн судалгааг гарган зурагжуулаад байна. Ерөө суманд 13 аж ахуйн нэгж 15510920 төгрөг, Хүдэр суманд 3 аж ахуйн нэгж 7457680 төгрөг, Баянгол суманд 7 аж ахуйн нэгж 5060400 төгрөг тус тус ногдуулан төвлөрүүлж ажилласан.

3. Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын талаар:

Энэ оны 3-р улирлын байдлаар аймгийн хэмжээнд нийт 715 иргэнд 86,24 га газрыг үнэ төлбөргүйгээр өмчлүүлсэн. Аймгийн Засаг даргын захирамжаар “Уул уурхайн нөлөөлөөр эвдэрсэн газрын тооллого” –ын ажлын хэсэг Ерөө, Хүдэр, Мандал, Түшиг, Орхонтуул, Баянгол сумдад ажилласан. Тооллогоор аймгийн хэмжээнд уул уурхайн нөлөөлөөр эвдэрсэн 3670,34 га газар бүртгэгдсэн. Үүнээс Баянгол суманд 160,94 га, Ерөө суманд 2746 га, Мандал суманд 53,38 га, Орхонтуул суманд 75,14 га, Түшиг суманд 109,54 га, Хүдэр суманд 490,03 га газар тус тус бүртгэгдлээ.

Мандал суманд газрын цахим биржээр 7 байршилд 2,68 га газарт газар эзэмших эрхийн дуудлага худалдааг зохион байгуулж орон нутгийн төсөвт 9.9 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

"Тендерүүдийг 100 хувь цахимаар зохион байгуулах зорилготой ажиллаж байна. 2017 оны 10 сард нийт шинээр 2 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж, тендер ирүүлэх шатанд Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хөдөө ажиллах

авто машин авах, Аймгийн нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт тоног төхөөрөмж авах 2 төсөл арга хэмжээ байна. 120,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Орхон Сэлэнгийн бэлчирт үерийн хамгаалалтын далан барих ажлын төсөв ирээгүй тул тендер зарлагдаагүй 1 төсөл арга хэмжээ байна.

Зургаа.Сүм орон нутгийн талаар:

Алтанбулаг сүм:

Сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд 10 дуугаар сарын 10-ны өдөр ногоочидтой уулзалт хийж, сумын ногоочдын төрийн бус байгууллага байгуулах, аймгийн Ногоочдын зөвлөгөөнд төлөөлөгч оролцуулах талаар санал солилцож, 25 ногоочин хамрагдсан. Аймгийн ногоочдын зөвлөгөөнд 4 ногоочин, “Сэлэнгийн ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд 5 ногоочинг тус тус оролцуулж үзэсгэлэн худалдааны үеэр 2,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

“Бэлчээрийн сэргэх чадавхи, ашиглагчдад суурилсан менежментийг боловсронгуй болгох туршлага” сэдэвт сургалт Гүн нуурын 3-р багийн байранд зохион байгуулагдаж, малчид, мал бүхий иргэд оролцлоо.

Сүм орон нутгаараа “Хэрэглэгч биш Үйлдвэрлэгч байх”-ын бизнес санааг хэрхэн олох, бизнесээ цаашид яаж хөгжүүлэх, бизнес төлөвлөгөөг боловсруулах, өөрийн нөөц боломж, чадвар, давуу чанараа олж харах чадварт сургах зорилгоор “Аж ахуй эрхлэлт”-ийн сургалтыг зохион байгуулж, 15 иргэнийг хамрууллаа.

Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр тусгагдсаны дагуу махны чиглэлийн “Ангус” үүлдрийн 4 бухыг “Гацуурт” ХХК-иас тус суманд гэрээ байгуулан авч, Чагтай” ХХК болон 2 малчин өрхөд гэрээгээр огоод байна.

Аймгийн Засаг даргын “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай” албан даалгавар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, Хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн албан тоот, Хүнс, Хөдөө аж ахуйн сайдын тушаалын дагуу малчид, мал бүхий өрхүүдийн малын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл, бэлчээрийн хүрэлцээ, отор нүүдэл, байран болон нэмэгдэл тэжээлээр тэжээх малын тоо, бэлтгэх тэжээлийн хэрэгцээ, малын усан хангамж, хашаа хорооны хангамж, мал эмнэлгийн үйлчилгээний талаар, малчин өрхийн бэлтгэлийг хангах, шалгах, дүгнэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг Борын жалга, Оргидог, Хутаг-Өндөр, Бааньтын гарам, Өвөрдулаан, Бөхлөө чиглэлийн 30 малчин өрхөөр ажиллаж, мал бүхий айл, өрхүүдийн өвөлжилтийн бэлтгэл, мал эмнэлгийн үйлчилгээтэй танилцаж, тус сумын Бөхлөө гэх газарт Төв аймгийн Борнуур сумаас 424 толгой малтай нүүж иргэнд тогтоол шийдвэрийн талаар танилцуулж, малтайгаа нүүх албан мэдэгдлийг өгсөн.

Гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжлийн чиглэлээр 2 удаагийн сургалтыг орчуулагч багш лектор Ганчулуунтай хамтран зохион байгуулж, 30 иргэнийг хамруулсан. Мөн “Цахим орчин ба хүүхэд хамгаалал” сэдвээр эцэг эхчүүдэд зориулсан сургалтыг зорилтод бүлгийн 24 иргэнд зохион байгуулсан.

“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн мэргэжил олгох арга хэмжээний сантехникийн сургалтыг 2017 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд Улаан баатар хотын барилгын технологийн коллежийн багш дулааны инженер мэргэжилтэй Төмөр овогтой Мөнгөншагай багшийн хамт сантехникийн сургалтыг зохион байгуулсан. Онол 40% дадлага 80 буюу нийт 120 цагийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэсэн. Сургалтанд Алтанбулаг, Сүхбаатар, Ерөө, Орхон, Сайхан сумаас нийт 22 иргэн бүртгүүлснээс төгссөн 19 иргэн суралцсан.

ЕББДСургууль нь Монголын багш нарын 51 дэх өдрийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд Багш нарын баярын бүсийн тэмцээнд 5 төрлөөр амжилттай оролцож, Г.Жамсранжавын нэрэмжит гар бөмбөгийн тэмцээн, “Сурагч багшийн өдөр” арга хэмжээг, 12-р ангийн 46 сурагч багш нар 1 өдрийн сургалтын ажлыг зохион байгууллаа.

Сумын 1, 2-р цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаагаа зохион байгуулах сэдвийн дагуу анги бүлгээ тохижуулан ажиллаж байна. “Хүн болох багаасаа” хөтөлбөрийн “Оюун ухааныг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд 7 хоногт 1 удаа англи хэлний сургалт явуулж байна. Хүүхдүүд үйл ажиллагаандаа идэвхтэй, сонирхолтой оролцож байна. Бэлтгэл бүлгийн хүүхдүүд цэцэрлэгийн ногоон байгууламжид хувь нэмрээ оруулж 4 төрлийн 18 ширхэг жимсний модыг эцэг эхчүүдтэйгээ хамтран тарилаа.

Нийтийн биеийн тамир, спортыг хүн амын эрүүл мэндийг хамгаалах, залуу үеийн бие бялдрыг чийрэгжүүлэх чиглэлээрб айгууллага, хамт олон, хувь хүний үүрэг, хариуцлыг өндөржүүлэх, идэвх санаачлагыг дэмжих зорилготой “Алтан тав” болзолт уралдааныг сумын Засаг даргын Тамгын газар, Дамбо цэцэрлэг, Найрамдал 1-р цэцэрлэг, ЭМТ-ийн ажилчдын дунд зохион байгуулж, уралдаанд байгууллага тус бүрээс 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр баг, нийт 20 хүн оролцлоо.

Тайлант хугацаанд сумын хэмжээнд эрэгтэй 26, эмэгтэй 34 нийт 60 хүүхэд мэндэлж, төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгож, 9 иргэн гэрлэлтээ бүртгүүлж, 5 иргэн шүүхийн шийдвэрээр гэрлэл цуцлалтын бүртгэлд бүртгүүлжээ. Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний 4, хүүхэд үрчилсний 1, эцэг тогтоосны бүртгэл 20, үүнээс эцэг, эхийн өргөдлөөр 18, гэрлэлтийн гэрчилгээгээр 2, нас барсны 22 бүртгэл хийснээс эрэгтэй 14, эмэгтэй 8 байлаа. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн чиглэлээр нийт 121 бүртгэл хийснийг ажлын 7 хоног тутам аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасгийн холбогдох улсын бүртгэгч нарт хүлээлгэн өглөө. Энэ хугацаанд 16 иргэн шилжин ирсэн, үүнээс бусад сумаас 2, бусад аймгаас 8, нийслэлээс 2 иргэн шилжин ирж, нийт 22 иргэн шилжин явсны бүртгэлийг тус тус хийж үйлчилсэн. Иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн болон хүчинтэй байдлыг алдагдуулсан 9, нийт 33 иргэний иргэний үнэмлэхийг дахин захиалах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Ерөө сум:

Сумын хэмжээнд аравдугаар сарыг “Ёс зүйг эрхэмлэж иргэдэд төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” сар болгон төр төсвийн байгууллагад төрийн хөтөчийн ажил арга хэмжээг зохион байгууллаа. Уг үйл ажиллагаагаар давхардсан тоогоор 3245 гаруй иргэд үйлчлүүлсэн бөгөөд албан хаагчдыг үйлчилгээнд санал асуулга авч ажиллалаа. Санал асуулгын дүнгээр хамгийн их иргэдэд үйлчилж сэтгэлд хүрсэн үйлчилгээ үзүүлсэн албан хаагчаар Нийгмийн халамж үйлчилгээний мэргэжилтэн шалгарлаа.

Мөн сумын Засаг даргын Тамгын газраас “Харилцаа” сарын аяныг “Бие биенээ хүндлэн эерэг харилцааг төлөвшүүлье” уриан дор зохион байгуулж, олон ажил арга хэмжээнүүдийг явууллаа. Энэ арга хэмжээнд багш, сурагч бүр эерэг харилцааны үгс бүхий мод ургуулан, анги болон хонгилд байршуулж бусадтай зөв мэндлэх, эерэг үгсээр бие биендээ урам дэмжлэг өгөх ажилд манлайлан оролцлоо.

Олон Улсын ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сумын эмэгтэйчүүдийн холбоо, “Их шинэстэй” ХХК хамтран “Ахмадын дуулах өдөр” арга хэмжээг зохион явуулж, 63 ахмад настан оролцсоноос гадна витаминь цуглуулга бэлэглэж, “АХА” асуулт хариултын хөгжөөнт тоглоомыг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд “Их шинэстэй” ХХК 200,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлээ. Мөн ажил үйлсээрээ тэргүүлсэн тэргүүний ахмад настнуудаа шагнаж урамшуулсан ба Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр ахмадын хорооны дарга Ч.Оюунцэцэг, ХАА-н тэргүүний ажилтан цол тэмдгээр ахмад настан Г.Оюунчимэг, Д.Хүрэлбаатар, ХНХЯамны Жуух бичиг”-ээр Ё.Алтанцэцэг, О.Норчиг нарыг шагнаж, ахмад настнууд өөрсдийн хийсэн цагаан идээ, хүнсний ногоогоор хийсэн бүтээлийн үзэсгэлэн худалдааг гаргаж, сайхан цай шалгаруулан урамшуулж, авъяаслаг уран бүтээлчдийн урлагийн тоглолтоор бэлэг барилаа.

Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх зорилгоор Засаг даргын тамгын газар болон Эрүүл мэндийн төвөөс хамтран 10 иргэнийг урьдчилсан эмчийн үзлэгт

хамруулсан ба орон даяар зохион байгуулагдсан цэргийн жинхэнэ албаны ээлжит татлагад сумын 55 иргэнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, 10 иргэн тэнцэж цэргийн жинхэнэ албыг хаахаар морьдлоо.

ЕБС-ийн “Эрдмийн өргөө” номын клубын сурагчид номын санчтай хамтран “Хуучин номын худалдаа”-г 6-12-р ангийн сурагчдын дунд уламжлал болгон зохион байгуулж, “Надад байгаа илүү зүйлс” сэдвийн хүрээнд өөрт байгаа илүү зүйлээ хуучин номын хамт худалдан борлуулах үйл ажиллагааг сурагчид өөрсдөө удирдан явуулж, нийт 10 анги оролцож 231 ширхэг номыг борлуулжээ.

Монгол Улсын ерөнхийлөгчийн “Номын баярын өдөр тэмдэглэх тухай” 2012 оны 158-р зорилгыг хэрэгжүүлэх, ард иргэд, хүүхэд залуучуудыг ном унших аянд уриалан дуудах, тэдний номтой харилцах соёлыг дээшлүүлэх зорилгоор “Ном бол оюун санааны тусгаар тогтнол” сэдэвт номын баярыг 1-12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулснаас гадна Олон Улсын Охидын өдрийг угтан 6-8-р ангийн сурагчдын дунд “Охидын бэлгийн хүчирхийлэл-хүрэхүйн тухай ярилцъя”, 7-9-р ангийн сурагчдад “Сарын тэмдгийн эрүүл ахуй”, 6-12-р ангийн сурагчдын дунд “Мансууруулах бодисоос урьдчилан сэргийлье” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан.

Сумын Засаг даргын захирамжаар “Газар тариалангийн бүс нутагт зөвшөөрөлгүйгээр мал тууварлан орж ирэхэд хяналт тавих” ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, Төв аймгийн Сүмбэр сумын бод, бог нийлсэн 736 толгой мал бүхий иргэнд сум орон нутгийн баримталж буй бодлого, шийдвэрийг танилцуулж ажиллалаа.

Сумын ургац хураалтын мэдээгээр 13633.2 га-д улаан буудай тарьснаас 13073.2 га-гаас 16343.9 тонн, төмс 89 га талбайгаас 1068 тонн, хүнсний ногоо 75,3 га-гаас 692 тонныг хураан авсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан ногоочдын зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаанд 8 иргэн 3 төрлийн хүнсний ногоо, 3 төрлийн дарж даршилсан бүтээгдэхүүн, мод модон эдлэл зэрэг бүтээлүүдээр оролцож, борлуулалт хийсэн.

Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан агч, шар хуайс, голт бор зэрэг нэр төрлийн нийт 96 ширхэг модыг нөхөн тарьсан.

Хог хаягдлын тухай хуулийн талаар 26 иргэнд, Ойн тухай хуулийн талаар 33, иргэнд, Түймрээс урьдчилан сэргийлэх зөвлөмж 18 иргэнд, Ургамлын тухай хуулийн тухай 29 иргэнд мэдээлэл өгч ажиллаа.

Хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох, орон нутгаас тээвэрлэж буй мод модон материалын тээвэрлэлтэнд хяналт тавих ажлыг 3 удаа гүйцэтгэж 1 зөрчлийг илрүүлэн холбогдох албан тушаалтанд шилжүүллээ.

Зүүнбүрэн сум:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн ээлжит 4 дүгээр хуралдаан хуралдаж сумын тариалангийн бүсийг тариалангийн талбайгаас 50 метрээр тооцон газар зүйн байршлаас хамруулан эрчимжсэн тариалангийн Боонги, Хутаг өндөр, Хус толгойн, Мангиртын бүсээр тус тус тогтоож, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2017 оны биелэлт, хэрэгжилтийн явц, 2018 оны төслийн тухай хэлэлцэж, 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2017 оны биелэлтийг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэлээ.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүд-2017” нэгдсэн арга хэмжээний “Алтан намар-2017” үзэсгэлэн худалдаанд оролцож, “Зохион байгуулалт сайтай сум”-аар шалгарсан.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат сонгогдсон тойрогтоо ажиллан Зүүнбүрэн сумын ард иргэд болон төрийн албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, санал бодлоо солилцон Эрүүл мэндийн төвд хүчилтөрөгчийн аппарат хандивлалаа.

Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн сурагчдад, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай хуулиас Нийтийн ёс суртахуун, хэв

журмын эсрэг зөрчлийн тухай ойлголтоор тус тус сургалт зохион байгуулж 140 гаруй сурагчдыг хамруулсан. Мөн Шаамар суман дахь мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу “Цэцэрлэгт хүрээлэнгийн цэцэрлэгч”-ийн ангийг суманд үнэ төлбөргүйгээр хичээллүүлж байгаа бөгөөд энэ сарын сургалтанд 15 иргэнийг хамрагдаж байна.

Монгол Улсад архивын салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан аймгийн Боловсрол соёл, урлагийн газраас “Архив бидний нүдээр” эссе бичлэгийн уралдааныг 10 дугаар сарын 02-ноос 16-ны хооронд зохион байгуулж Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 10а ангийн сурагч Д.Даваагэрэл, Ц.Золбоо, 12б ангийн сурагч Ц.Төрболд нарын материалыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүллээ.

Ахмадын баярыг тохиолдуулан “Бид чадна” тэмцээн, “Дуун цэнхэр хадаг” дууны тэмцээн, хүндэтгэлийн хүлээн авалтыг тус тус зохион байгуулж, зарим ахмад настанг аймаг, сумын Засаг даргын жуух бичгээр шагнаан урамшууллаа.

Сумын хэмээнд малчин, мал бүхий 461 өрхийн 64666 толгой мал өвөлжинө. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд өвс 8000 тн, тэжээл 30 тн, ногоон тэжээл 6000 тн, сүрэл 420 тн, дарш 1200 тн, хужир 10 тн-ыг тус тус бэлтгэл өвөлжилтийн бэлтгэл ажил 78.8 хувьтай хангагдаад байна. Сумын өвсний аюулгүйн нөөцөнд 80 тн өвч, 1.2 тн тэжээл төвлөрүүлэн ажиллаа.

“Монгол мал” үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, малын үүлдэр угсааг сайжруулах, малчид, мал бүхий иргэдийн үйлдвэрлэлийг дэмжих, бүтээгдэхүүний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Гацуурт” ХХК-нд үржүүлж буй махны чиглэлийн хар, улаан Ангус үүлдрийн 4 толгой бухыг мал хамгаалах сангаас нэг бүрийг 5.0 сая төгрөгөөр үнэлэн Зүүнбүрэн сумын Шимт бүрэн ХХК-д өвөлжүүлж байгаа бөгөөд малчидтай гэрээ байгуулан ажиллаж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Малчид, тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”, Тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын байгаль орчин, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн бодлогын хороонд танилцууллаа.

Халдварт цэцэг өвчний тайван бус нутаг дэвсгэрээс оторлож яваа Төв аймгийн 2 малчин өрхийн 1562 толгой малын хашаа, байр, өтөг бууцыг мал эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлтэнд, 1450 толгой малыг угаалга, туулгалтанд хамруулах ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар тогтоолын дагуу бүх нийтийн мод тарих үндэсний өдрөөр сумын хэмжээнд 4793 ширхэг мод, сөөг, жимс жимсгэнэ тариалж 1260,0 мянган төгрөгийг зарцуулсан.

Нийгмийн халамжийн сангаас жирэмсэн, нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 86 иргэнд 2.8 сая, халамжийн сангаас тэтгэвэр авагч 78 иргэнд 95.0 сая, асаргааны тэтгэмж авагч 26 иргэнд 1.8 сая, бүрэн хараагүй иргэний харилцаа холбооны зардал 6 иргэнд 80.000, онцгой тохиолдлын амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж авагч 19 иргэнд 1.1 сая нийт 13.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олголоо.

2014-2016 онд зээл авсан, хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдтэй уулзаж зээлээ хугацаанд төлүүлэх тал дээр анхаар графикайн дагуу төлүүлэхээр 10 иргэнд мэдэгдэл өгсөн. Мэдэгдэлийн дагуу 7 иргэний зээлийг төлүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 35981000 төгрөгийг төвлөрүүллээ.

Ажилгүйдлийн бүртгэлд 2, шинэ ажлын байранд 8 иргэн бүртгэгдээд нийт шинэ ажлын байр 39 байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.

Тайлант сард хүүхэд өдрийн төлөвлөгөөгөөр 2400 хүүхдийг хамруулахаас 2265 хүүхэд өдөр хамруулж 94 хувь, 24 цагийн ажиллагаатай бүлгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөнд 320 хүүхэд хоног хамруулахаас 192 хүүхэд хоног хамруулж 60

хувьтай байна. Бүлэг бүр эцэг эхийн хурал зохион байгуулж, эцэг эхийн зөвлөлөө сонгон, эцэг эх-багш- цэцэрлэгийн эрхлэгч гэсэн гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна.

ЕБС-иас багш нарын баярыг тохиолдуулан “Хишиг өдөр” арга хэмжээг зохион байгуулж багш, ажилчид албан тушаалаа сэлгэн ажилласан. 2017-2018 оны хичээлийн жилийн сурагчдын мэдлэг чадварыг тогтоох гарааны үнэлгээг “Цахим сорилго” ХХК-тай хамтран хэрэгжүүлж 464 сурагчийг хамрууллаа. Мөн сэтгэх чадварын намрын их сорилгод Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 6-9 ангийн 100 сурагчийг хамрууллаа.

Энэ хичээлийн жилд Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуульд жүдо, гар бөмбөг, технологи, бишгүүр хөгжим, шатар зэрэг секц, дугуйлан хичээллэж байна.

Сумын эрүүл мэндийн төвд 2 иргэн хэвтэн эмчлүүлж, амбулаториор 276 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 138, урьдчилан сэргийлэх үзлэгээр 88, диспансерийн хяналтаар 19, гэрийн идэвхтэй эргэлтээр 21, дуудлагаар 10 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүллээ. Ээлжит товлотт вакцинд 1 хүртэлх насны хүүхдүүдийг 100 хувь хамруулж, эх хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээл хөтөлбөрийн дагуу зорилтод бүлгийн 16 хүүхдэд олон найрлагат бичил тэжээлийн холимог олголоо.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон олон нийтийн түвшинд мобайл технологийг нэвтрүүлэх нь төсөлд 18-65 насны хамрагдвал зохих 1682 иргэнээс 1557 иргэнийг хамрууллаа. Зорилтод бүлгийн 1200 иргэнийг программд шивж орууллаа.

Иргэний гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шинэ төрсөн 7, эцэг тогтоолт 5, овог нэр өөрчлөлт 1, үрчлэлт 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 15, иргэний үнэмлэх гээгдүүлээд дахин авах 6, иргэний үнэмлэх олголтын 15, шилжин явсан 3, шилжин ирсэн 8 нийт 61 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

Мандал сум:

Сумын хэмжээнд энэ онд улаан буудай 5162,6 га талбайгаас 1650 тн ургац, тэжээлийн ургамал 123 га 823 тн, төмс 600 га талбайгаас 4060 тн, хүнсний ногоо 389,5 га талбайд тариалж 6500 тн ургац хураан авсан. Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаанд өрхийн тариаланч эрхлэгч бүлэг хоршоодын төлөөлөл 7 хүнийг оролцуулж, Түнхэл сүү хоршо шилдэг борлуулагч, Зүүнхараа агро тариалалт борлуулалтын хоршоо нь Шилдэг үйлдвэрлэгч хоршоогоор шалгарлаа. Мөн төв суурин газрын хүн амыг экологийн цэвэр төмс, хүнсний ногоогоор хангах зорилгоор Улаанбаатар хотод 4 цэгт 26 хүн хүн борлуулалт хийж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын удирдамжийн дагуу хүнсний ногоонд /лууван, байцаа, сонгино/ пестицидийн үлдэгдлийн шинжилгээнд 25 дээж авч хамрууллаа. Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Монгол ногоо төслийн дунд хугацааны мониторинг хийгдэж, цаашид хэрэгжүүлэх ажил арга хэмжээгээ төлөвлөлөө.

Хадлан тэжээл бэлтгэлийн мэдээг сумын малтай айл өрх бүрээр гарган Сумын 2017-2018 оны мал өвөлжилтийн ажлын тайланг нэгтгэн аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлж, Тарни, Төмөр замчдын 1-р багийн 200 үхэр сүрэгт ангилалтын ажлыг хийгээд байна. Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор Цагааннуур сумын “Гацуурт” ХХК-ий махны чиглэлийн ангус үүлдрийн 5 бухыг авчирч орон нутгийн иргэдэд олгосон.

Сумын нутаг дэвсгэр Арцатын аманд үйл ажиллагаа явуулж буй “Сонгоулд” ХХК-ий олборлолтын талбай, баяжуулах үйлдвэрт холбоогдох нэгжүүдийн хамтарсан хяналт шалгалтыг, Тэрхтийн ар “Гахайт” гэх газар үйл ажиллагаа явуулж аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдэд мөн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, “Тэлмэн оргил” ХХК-ний үйл ажиллагааг түр зогсоож зөрчил дутагдлаа арилгах шаардлага тавьсан.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдрийг Мандал сумын “Соёнбот” талбайд зохион байгуулж, ойн мэргэжлийн болон

мод модон материал үйлдвэрлэгч 7 аж ахуйн нэгж оролцон 50 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

Сумын Баянхангайн 6-р багт байрлах хогийн нэгдсэн цэгийн тархалтын талбайг багасгах ажлыг эхлүүлж, 5 га талбайн хогийг бүрэн цэвэрлээд байна.

Сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр ахмадын өргөө, ахмадын сувилалын цогцолбор байгуулахаар хуучин эмнэлгийн зориулалттай ашиглагдаж байсан барилгыг засварлаж, ашиглалтад оруулахад бэлэн болголоо. Мөн Төмөр замчдын 1-р багт 2 га талбай бүхий хүүхэд залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнб айгуулах зорилгоор 20м өндөртэй талбайн гэрэлтүүлэг суурилуулж, 800м төмөр хашаа, хөл бөмбөг, гар бөмбөгийн талбайнууд байгуулж, 2ш сүүдрэвч барьж, 200ш мод тарьсан.

Дэлхийн багш нарын 23, Монголын багш нарын 51 дахь өдрийн баярын хурал, Түнхэл тосгоны Төгөлхөн цэцэрлэгийн 50 жил, Улсын тэргүүний Нархан цэцэрлэгийн 10 жил, Цэцэгхэн цэцэрлэгийн 50 жилийн түүхт ойн баяруудыг амжилттай зохион байгуулсан.

Олон Улсын ахмадын баярыг тохиолдуулан “Миний сайхан Мандал сум” сэдвээр 1, 6-р багийн ахмадуудын дунд асуулт хариултын “АХА” тэмцээн зохиож, тэмцээнд 62 ахмад оролцлоо.

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээнд 337 иргэний материал хүлээн авлаа. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 66 өрхөд 9-р сарын хүнсний эрхийн бичгийг олгож, тайлан гаргалаа.

Баруун хараа ТББ-тай хамтран зорилтот бүлгийн өрхийн хүүхдүүдэд дулаан хувцасны дэмжлэг үзүүллээ.

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны мэдээллийг бусад сангуудтэй тулгахад 2345 өрхийн мэдээлэл зөрүүтэй байсныг иргэн бүртэй холбогдож шаардлагатай баримтыг үндэслэн баталгаажууллаа.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхдийн асрагч нарт холголт цооролтоос урьдчилан сэргийлэх, арьсны эрүүл ахуйг сахих, цусан хангамжийг сайжруулах, арьс гэмтэхээс сэргийлэх гэрийн сувилгааг хэрхэн хийх тухай мэдээллийг 50 иргэнд өглөө.

“Ажлын байр” сэдэвт өдөрлөгөөр МЭ БРҮГ ХХК-тай хамтран 11 иргэнд 25 ортопедийн хэрэгсэл олгосон.

Орхон сум:

Аймгийн Засаг даргын 2017 оны 08-р сарын 30-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаас гарсан шийдвэр, аймгийн ЗДТГ-ын даргаас өгөгдсөн үүрэг чиглэл, аймгийн ЗДТГ-ын 2017 оны 2/395 тоот “Захирамж, шийдвэрийн төсөл боловсруулахад баримтлах зөвлөмж”-ийг хэрэгжүүлж ажиллахтай холбогдуулан “Зөв төлөвлөө, төгс гүйцэтгэе” уриатайгаар “Цэгцтэй алба- чадварлаг албан хаагч” 14 хоногийн аяныг зохион байгуулж, 19 цогц арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан. Аяны хүрээнд тус сумын Тамгын газрын албан хаагчдад Захиргааны ерөнхий хууль, зөрчлийн тухай хуулиар сургалт хийж, төрийн албан хаагчид өөрт хамааралтай хууль эрх зүйн баримт бичгүүдийг хэрхэн мэдэж байгааг шалгахад захиргааны ерөнхий хууль болон зөрчлийн хуулиар шалгалт авч хууль эрх зүйн мэдлэгийг нь дээшлүүлэн ажиллалаа. Мөн төрийн албан хаагч бүрийг өдөр тутам хэрэглэдэг хууль эрх зүйн баримт бичгүүд болон бусад гарын доор хэрэглэх баримтуудаар баяжуулсан “Ширээний лавлах” нэгдсэн хавтастай болгож, бичиг хэргийн эмх цэгцийг бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд сумын Засаг даргын 2017 оны А/02 тоот захирамжийн хүрээнд зохион байгуулагддаг төр төсвийн байгууллагын менежрүүдийн ажил төрлийн мэдээ мэдээлэл солилцох, үүрэг чиглэл өгөх уулзалт 2 удаа, ЗДТГ-ын төрийн албан хаагчдын ажил төрлийн яриа 1 удаа зохион байгуулагдаж Засаг даргаас төр төсвийн байгууллагын дарга эрхлэгч, ЗДТГ-ын төрийн албан хаагчдад салбар чиглэл бүрээр үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Сумын ЗДТГ-аас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар 3 иргэнд амаар мэдээлэл өгч, 53 ширхэг гарын авлага бэлтгэн тарааснаас гадна Захиргааны ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж олгох тухай хууль, газрын тухай хууль, Нийгмийн халамж үйлчилгээний тухай хууль зэрэг хуулиудаар иргэдэд мэдээ мэдээлэл өгч давхардсан тоогоор 98 иргэнийг хамруулсан байна.

Тайлант хугацаанд Орхон суманд хүүхэд залуучуудын тоглоомын талбайн хашааг шинэчлэн сагсан бөмбөгийн талбайг стандартын хашаатай болгох хүүхдийн тоглоомын өнгө үзэмжийг сайжруулах будах зэргээр “Тоглоомын талбай” засварлах ажилд төв суурин газрын ажилгүй 5 иргэнийг түр ажлын байраар ханган ажилласан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт Хамтарсан багийн гишүүдийн судалгаа, хамтарсан багийн үйл ажиллагааны тайлан, хөгжлийн бэрхшээлтэй 0-18 хүртэлх насны хүүхдийн нарийвчилсан судалгааг гарган хүргүүлж, 12-р цэцэрлэгээс зохион байгуулсан “Найзууддаа тусалъя” сэтгэлийн аянд ЗДТГ-ын хамт олныг хамруулж 94500 төгрөгөөр хандив өргөлөө.

Сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн 2017 оны 10-р сарын 11-ний өдрийн хуралдаанаар байнгын асаргаа шаардлагатай ахмад, хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаа шаардлагатай хүүхэд, иргэний байнгын асаргааны сунгалт болон тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд түлээ нүүрсний хөнгөлөлт бүрэн хараагүй хэлгүй дүлий иргэний түлээ нүүрсний хөнгөлөлт хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн түлээ нүүрсний хөнгөлөлтийн материалыг бүрдүүлж ХХҮ-ний газарт хүргүүлж, 10 дугаар сарын байдлаар нийт давхардсан тоогоор 651 иргэнд 157,371,610 төгрөгийг тус тус олгож ажилласан.

Нийгмийн даатгалын алба нь 10-р сард төсөв аж ахуй нэгж байгууллагаас шимтгэлийн орлого 17434.1 мянган төгрөг, сайн дурын даатгалд 35 даатгуулагчийн 1113.6 мянган төгрөг, ЭМД-д 25 даатгуулагчийн 1225,0 мянган төгрөгийг санд оруулж, Нийгмийн даатгалын сангуудын хуваарилалтыг хийсэн. Үүнд: Тэтгэвэрийн даатгалын санд мянган төгрөг, ҮОМШӨ-ний санд 350.0 мянган төгрөг, ЭМД-ын санд 6500,0 мянган төгрөг, Ажилгүйдэлийн санд 442.9 мянган төгрөг мянган төгрөгийн хуваарилалтыг хийж, Өндөр насны тэтгэвэр 282 хүнд 79978,6 мянган төгрөг, Тахир дутуугийн тэтгэвэр 78 хүнд 17741,7 мянган төгрөг, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 22 хүнд 5172,0 мянган төгрөг, Цэргийн тэтгэвэр 3 хүнд 1507,9 мянган төгрөгийн тэтгэвэрийг тавьж олгосон. Мөн тэтгэмжийн сангаас ХЧТА-ны тэтгэмж 4 даатгуулагчдад 450,4 мянган төгрөг, жирэмсэн, амаржсаны тэтгэмж 3 даатгуулагчид 2062,4 мянган төгрөг, оршуулгын тэтгэмж 1 иргэнд 1000,0 сая төгрөгийг, ажилгүйдэлийн сангаас ажилгүйдлийн тэтгэмж 2 даатгуулагчид 617,0 мянган төгрөгийг, ҮОМШӨ-ний сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 1 хүнд 311,7 мянган төгрөгийг олгосон.

Монголын бэлчээр ашиглалтын нэгдсэн холбоо, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, Газрын албатай хамтран “Бэлчээр ашиглалтыг зохион байгуулах” нь сургалтыг сумын хэмжээний малчин, мал бүхий бүхий иргэдэд зохион байгуулсан.

Сумын Засаг даргын 2017 оны А/132 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдан “2017-2018 онд өвөлжилтийн бэлтгэл ажил хангах арга хэмжээний төлөвлөгөө” батлуулан ажиллаж байна.

2017 онд зөвхөн малын тэжээл бэлтгэх зориулалтаар хадлан өгөхөөр өрхийн малын тоо толгойд тохируулан 244 малчин, мал бүхий иргэнтэй 1734 га-д хадлангийн гэрээ байгуулсан. Малчид малын тэжээлийн зориулалтаар 1230 тн хадлан бэлтгэх шаардлагатай байгаагаас 65% буюу 800 тн өвсийг бэлтгэж нөөцлөөд байна. Үлдэх 35 хувь буюу 430 тн-ыг гаднаас худалдаж авах замаар бэлтгэх төлөв байдалтай байна. Тус сум гадны аймгийн болон өөрийн аймгийн суманд оторлох, өвөлжих малчин өрх байхгүй байна. Өнгөрсөн жилд тооллогдсон малын 30-35 хувийг нядалж зах зээлд борлуулахаар тооцож сумын хэмжээнд 1679,8 тн мах бэлтгэн зах зээлд борлуулж эдийн засгийн эргэлтэнд оруулах тооцоог гаргасан.

Намрын ургац хураалтын ажил дууссантай холбогдуулан тариалалтын эцсийн мэдээг 35 аж ахуйн нэгж 145 иргэдийн судалгааг гаргаад байна. Улаан буудай нийт 8155 га талбайд тариалалт хийж 12084 тн ургац га-ийн ургац 14,8 цн, овъёос 60 га талбайд тариалалт хийж 90 тн ургац га-ийн ургац 15 цн, тосны ургамал 3167 га талбайд тариалалт хийж 2867 га талбайг хураан авч 1061,5 тн га-ийн ургац 3,7 цн, төмс 340 га-с 4420 тн, га-ийн ургац 13цн, хүнсний ногоо 120 га-с 1694 тн га-ийн ургац 14 цн-ийг тус тус хураан аваад байна.

Байгалийн хадлан 8000 тн-ийг бэлтгэснээс малчны хадлан 3200 тн, бизнесийн хадлан 4800 тн-ийг тус тус бэлтгэсэн.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 тоот “Бүх нийтээр мод тарих өдөр зарлах тухай” зарлиг, Сумын ИТХ-ын 2017 оны 20 тоот “Ногоон төгөл” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, мод бут тарих ажлын хүрээнд хүүхдийн тоглоомын 1 га талбайд 302 ширхэг, төв зам дагуу 30 ширхэг нийт 332 ширхэг нарс модыг тарьж суулгасан. Тус ажилд төр төсвийн 5 байгууллага, 2 аж ахуй нэгж, ЕБС-ийн 12-р ангийн 15 сурагч нийт 65 иргэн оролцсон. Мөн Шийр суурингийн айл өрхөд 60 ширхэг нарсны суулгацыг үнэ төлбөргүй олгосон. Сумын ЗДТГ, Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэнтэй хамтран модны үзэсгэлэн худалдааг зохион байгуулан чацаргана, үхрийн нүд, монос, бөөрөлзгөнө, интоор, хөх далан хальс, голт бор, агч зэрэг 8 төрлийн жимсний модны нийт 193 ширхэг суулгацыг 24 иргэн, төр төсвийн 4 байгууллага 45 ширхэг модны суулгацыг худалдан авч тарьсан байна.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрөлгүй ховор ургамал болох Дэрэвгэр жиргэрүүг түүхийг завдсан Сайхан сумын харъяат иргэн Т.Зургаанжинд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 150000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, 3 ширхэг үндэс түүдэг багажийг хураасан. Мөн Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 0170007 тоот “Байгалийн ховор ургамалыг түүж, бэлтгэх зөвшөөрөл”-ийн дагуу, Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 322, 347 тоот албан бичгийн зөвшөөрлийн дагуу байгалийн ховор ургамал болох Дэрэвгэр жиргэрүүг Орхон суманд 2 тн бэлтгэх зөвшөөрөл гарсантай холбогдуулан “Ноён ширхэнцэг” ХХК, “Эко петролиум” ХХК-тай тус тус 1 тн гэрээ байгуулан байгалийн ховор ургамалыг бэлтгүүлэн 2017 оны 10 сарын 13-нд гэрээний хугацаа дуусгавар болгоод байна.

Орон нутгийн байгууллагуудын төсвийн санхүүжилтийн зарцуулалтын гүйлгээг батлагдсан төсвийн дагуу анхан шатны баримтыг үндэслэн нийт 102805592 төгрөгийн гүйлгээ хийгдсэн. 2017 оны төсвийн гүйцэтгэлийн 8 сарын мэдээг гаргаж /shilendans.gov.mn/ шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулсан.

Сант сүм:

Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах эцсийн мэдээг нэгтгэн гаргаж 2017-2018 оны өвөл, хавар 2 багийн 214 хот айл, 233 өрхөд 81219 толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 158508 мал өвөлжүүлж хаваржуулна. Бэлчээрийн ургац 2 цн ба хүрэлцээ хангамж 67,2 хувь байна. Сумын хэмжээнд хонин толгойд шилжүүлснээр 11600 мал байран тэжээлд, 29200 мал нэмэгдэл тэжээлд оруулна. Сумын хэмжээнд 5944 тн хадлан, 1189 тн хүчит тэжээл, 238 тн эрдэс тэжээл бэлтгэх төлөвлөгөөтөйгөөс 5600 тн хүчит, 1200 тн хүчит, 238 тн эрдэс тэжээл бэлтгэн авч тэжээлийн хүрэлцээ 96,3 хувьтай байна. Сумын аюулгүйн нөөц бүрдүүлэх зорилгоор 4 иргэнтэй гэрээ хийн 80 тн өвс бэлтгүүлэх ажлыг хийж байршуулж эхлээд байна. Мал өвөлжүүлж хаваржуулахад 11 инженерийн хийцтэй, 25 гар худаг, 1 усан сан нийт 37 уст цэг ажиллан 233 өрхийг усаар хангана. 152 бодын, 210 богийн өвөлжөө шаардлагатай байгаагаас шинээр 5 өвөлжөө баригдан хангалт 100 хувьтай, сумын нэгдсэн дүнгээр мал өвөлжилтийн бэлтгэл ажил 89,5 хувьтай хангагдаад байна.

Сумын ургац хураалтын ажил дуусаж үр тариа 1535 га талбайгаас 1685,4тн, төмс 200 га талбайгаас 2980 тн, хүнсний ногоо 125,1 га талбайгаас 1572,1 тн ургац тус тус хураан авсан байна.

Аймагт зохион байгуулагдсан “Сэлэнгийн ногоон өдрүүд -2017” үзэсгэлэн худалдаанд сумаас 3 иргэн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 935000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран Гачуурт компанаас олгож байгаа шилмэл үүлдрийн бух олгох ажлын хүрээнд малчин Г.Түмэнхүү, Б.Жаргалцогт нарт улаан абердин ангус үүлдрийн 2 бух олгон гэрээ хийсэн байна.

Газрын харилцааны чиглэлээр “Сэлэнгэ тулга” ХХК-тай хамтран захиалга өгсөн 16 иргэний өмчлөл, эзэмшлийн газарт кадастрын зураглал хийлгэж хамтран өмчлөл хасуулсан 52 иргэн, насанд хүрээгүй 49 иргэнд газар өмчлүүлсэн талаар дэлгэрэнгүй судалгааг гаргасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63-р зарлиг, аймгийн Засаг даргын А/407 тоот захирамжийн дагуу сумын хэмжээнд бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулж төр төсвийн байгууллагууд нийт 9 төрлийн 542 мод тарьж ногоон байгууламж нэмэгдүүлсэн байна.

Хамтын оролцоотой ойн тогтвортой менежмент төслөөс Сант сум болон Баруунбүрэн сумын ойн нөхөрлөлүүдийн дунд хаягдал мод ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэх 3 үйлдэл бүхий зөөврийн төхөөрөмжийг Сант сумын “Хан хушаат” нөхөрлөлд хүлээлгэж өгсөн байна. Энэ үеэр нөхөрлөлүүд болон иргэдийн дунд төхөөрөмжийг танилцуулах үзүүлэх сургалт, тэмцээн зохион байгуулагдсан байна.

Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан “Ахмадын баяр-2017” хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулагдаж 150 гаруй ахмад настан хамрагдсан байна. Энэ үеэр суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд харъяаллын ахмадууддаа гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлсэн байна. Ахмадын баярын өдрийг тохиолдуулан ахмадуудад туслах аяны хүрээнд “Аваргын хишиг ахмадуудад” гэсэн арга хэмжээ зохион байгуулагдаж сумын сайн малчин Б.Чулуунхүү, мянгат малчин Ч.Жамсранжав нараас сумын төвийн амжиргааны түвшин доогуур ганц бие өндөр настан 5 ахмад настанд хандив болгож 3 хонь, 3 ямаа олгосон байна.

Орон нутгийн татварын орлого 33163,6 мянган төгрөг орохоос 72200,0 мянган төгрөг төвлөрч гүйцэтгэл 234,2 хувьтай орлого 39036,4 мянган төгрөгөөр даваад байна. Аймгаас авах санхүүгийн дэмжлэг 166277,5 мянган төгрөгийг бүрэн авч орон нутгийн байгууллагуудад 215408,3 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоос санхүүжилт 100% олгогдсон байна.

Соёлын ажилтны өдрийг тохиолдуулан “Соёл-Урлаг-Түүх” 10 хоногийн аян амжилттай явагдаж байна. Аяны хүрээнд уламжлал болон явагддаг явган аялалын тэмцээн 10 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 7 багийн 49 гишүүн, хөгжөөн дэмжигчид нийт 65 хүн хамрагдсан байна.

Цагааннуур сум:

Сумын төр, төсвийн байгууллагуудын удирдах ажилтны цугларалтыг 2 удаа зохион байгуулж цаг үеийн мэдээллүүдийг хэлэлцлээ.

Монголын ахмадын өдрийг тохиолдуулан сумын ахмад настнуудын судалгааг үндэслэн ахмад настнуудыг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд харъяалуулж, баярын хурал, “Хос бүжгийн тэмцээн”, “Дууны тэмцээн”-ийг явуулж, сумын уран сайханчдын тоглолтыг зохион байгууллаа.

Сумын дүнгээр энэ онд нийт 33022 тн үр тариа, үүнээс 26861 га-гаас 32134 тн буюу 11,9 цн улаан буудай, 4016 га-гаас 1540 тн буюу 3,8 цн рапс, 3269 га-гаас 997 тн буюу 3 цн тэжээлийн ургамал, төмс 221,33 га талбайгаас 2985,1 тн, хүнсний ногоо 186,71 га талбайгаас 2979,58 тн-ыг тус тус хураан авсан.

Аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулагдсан ногоочдын зөвлөгөөнд 3 ногоочин оролцсон.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 10-р сарын 24-ний байдлаар 26000,0 мянган төгрөгийг төвлөрүүлж, ТЭДС-аас олгосон бага оворын тракторын зээлийг төлүүлэх талаар мэдэгдэх хуудас хүргүүлээд байна.

Энэ онд тус суманд нийт 187370 толгой мал өвөлжихөөр тоологдсон 11681,0 тн хадлан, 40 тонн сүрэл, 4000 тонн дарш, 235 тонн хужир шүү бэлтгэж, өвөлжилтийн бэлтгэл 98,0 хувьтай байна. Умын өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд 145,0 тн өвс, 40,0 тн тэжээл бэлтгэсэн. Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамруулж, сумын Засаг даргын захирамжаар “Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын аяныг энэ сарын 14-25-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг арга хэмжээг “Таван хишиг”, “Сэлэнгэ буян хишиг”, “Дэвжих дөл”, “Дөрвөн бүдүүн” зэрэг мал эмнэлэг үржлийн нэгжүүд гэрээ байгуулан малчин, мал бүхий өрх, аж ахуйн нэгжүүдийн хурга, ишиг, тугал гэх мэт бүгд 43610 толгой төлийг хамруулсан.

Сумын татварын орлого 10 дугаар сард 71786,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 10-р сарын 23-ны байдлаар 88431,2 мянган төгрөгийг төвлөрүүлж, 123,2 хувийн биелэлттэй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж, мэдээллийг тухай бүр байршуулж байна.

Тайлант сард нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас 381 өндөр настанд 103851,2 мянган төгрөг, 59 тэжээгчээ алдсан иргэнд 14296,1 мянган төгрөг, 189 тахир дутуу иргэнд 45475,2 мянган төгрөг, 4 цэргийн өндөр настанд 12270,1 мянган төгрөг, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалан өвчний даатгалын сангаас 5 иргэнд 13086,0 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 13 иргэнд 8733,5 мянган төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсаны болон жирэмсэн амаржсаны, оршуулгын тэтгэмжинд олгосон.

Баянгол сум:

Сумын Засаг даргын Тамгын газар, төр төсвийн байгууллагуудаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Сумын Засаг даргын захирамжаар өвөлжилтийн бэлтгэл хангах, цаг үеийн ажлыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 186-р тогтоол, аймгийн Засаг даргын албан даалгавар, Хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Ерөө сумаас 1500 боодол өвч бэлтгэж, 2 тонн тэжээлийн будааг нөөцлөөд байна. Малын гоц халдварт өвчний дэгдэлттэй холбогдуулан бусад аймаг, сумдаас мал амьтад оруулахгүй байх талаар хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж замын цагдаагийн шалган нэвтрүүлэх постод эргүүл хяналтыг ажиллуулж байна.

Намрын ургац хураалтын дүнгээр 5398 га-гаас 3268,1 тонн улаан буудай, 106 га-гаас 84,8 тонн овъёос, 42 га-гаас 153 тонн гурвалжин будаа, 47 га-гаас 42 тонн ногоон тэжээл, 357 га-гаас 70 тонн тосны ургамал хураан авсан. Төмс хүнсний ногооны тариалалтын хувьд төмс 87 га-гаас 583 тонн, хүнсний ногоо 88,9 га-д тариалснаас 642 тонныг тус тус хураан авлаа. Аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулагдсан ногоочдын зөвлөгөөнд сумын 6 ногоочин оролцсон.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 3 удаагийн эргүүл шалгалтыг зохион байгуулж, мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан нийтийн эзэмшлийн талбайд 200 суулгац тарьж суулгасан. Сумын хэмжээнд золбин нохой устгах ажлыг зохион байгуулж, 65 нохойг устгасан.

Суманд үйл ажиллагаа явуулж буй “Майнд Тэч” ХХК-тай хамтран ажлын байрны нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, 86 иргэнийг хамруулан мэдээлэл өглөө. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 3 ахмад мэргэжилтнийг хамруулж 840,0 мянган төгрөгөөр урамшуулсан.

Нийгмийн халамжийн тэтгэвэр 84 иргэнд 11723,1 мянган төгрөг, асаргааны тэтгэмж 49 иргэнд 3193,8 мянган төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 32 иргэнд 2720,0 мянган төгрөг, ахмад настны хөнгөлөлтөнд 6 иргэнд 959,0 мянган

төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт 14 иргэнд 1868,0 мянган төгрөгийг хугацаанд нь олгож, амьжиргааны түвшин тогтоох судалгааны зөрүүтэй мэдээллийг баталгаажуулах арга хэмжээнд 622 өрхийг хамруулав.

Орон даяар зохион байгуулагдсан цэргийн жинхэнэ албаны ээлжит татлагад 18-26 насны 262 иргэнд зарлан мэдэгдэх хуудас тарааж, 53 иргэн эмч нарын үзлэгт хамрагдаж, 5 иргэн цэргийн албанд мордсон.

Сумын соёлын төвөөс холбогдох газруудтай хамтран Монголын багш нарын 51 дэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сургууль, цэцэрлэг, соёлын төвийн ажилтан албан хаагчдын урлагийн тоглолтыг зохион байгуулж, 180 хүн үзэж сонирхсон. Мөн Олон Улсын ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлж, урлагийн тоглолт, дууны уралдаан нийтийн бүжгийн тэмцээнийг явуулж, 250 гаруй ахмад настан хамрагдлаа.

Сумын эрүүл мэндийн төвөөс амбулаториор нийт 501 иргэнийг үзлэгт хамруулж, дээд шатлалын эмнэлэгт 16 иргэнийг онош тодруулахаар илгээж, 196 иргэнд өдрийн эмчилгээг эмчийн заалтаар хийж үйлчилсэн. Эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл хөтөлбөрийн хүрээнд 0-5 насны 133 хүүхдийг жинлэн, товллын дархлаажуулалтанд 100 хувь хамруулсан. Төрийн албан хаагчдын дунд хөдөлгөөний хомсдолоос үүдэлтэй илүүдэл жин, таргалалтаас урьдчилан сэргийлэх зөв хандлагыг төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулж, 124 төрийн албан хаагч хамрагдсан.

Сайхан сүм:

Сумын Ахмадын баярыг Хөтөл 1, Гавшгай 2, Номгон 3 дугаар багийн хэмжээнд “Ахмадаа хүндэлье” уриан дор “Яг түүн шиг”, “Сайхан цайтай ээж” уралдаан, “Сэтгэл шингэсэн миний оролцоо” сайн үйлсийн аян зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулсан. Баярын үйл ажиллагааны үеэр “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль”-р танилцуулга хийж, улс эх орныхоо бүтээн байгуулалтанд үнэтэй хувь нэмэр оруулж явсан 32 ахмад настныг Сумын Засаг даргын жуух, Монголын ахмадын хороо, аймгийн ахмадын хорооны хүндэт тэмдэгээр шагнасан бөгөөд сумын соёлын ордны уран бүтээлчид тоглолт үзүүлж, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулж 350 гаруй ахмадууд хамрагдлаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд замын хөдөлгөөны аюулгүй байдал, малын хулгай, мөн зөрчлийн тухай хуулийг ард иргэдэд танилцуулах ажлыг Номгон 3-р багийн албан хаагч нарт сургалт зохион байгуулан ажиллаа. Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар гарын авлага материалыг бэлтгэн байгууллагын албан хаагчид болон иргэдийн дунд сургалт зохион байгуулан ажилласан байна. Мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах бүс хэрэглэх, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар танилцуулга, гарын авлага тараах материал хүргүүлэн ажилласан байна.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төр, төсвийн байгууллага болон аж ахуй нэгж байгууллага, иргэдэд бүх нийтээр мод тарих ажилд идэвхтэй оролцохыг уриалан Засаг даргын Тамгын газраас мод тарих газрыг хувиарлан өгч бургас, улиас, халиас, жимсний модны тарьц суулгацаар хангах, хэрхэн тарих заавар зөвлөгөө хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Сумын ургац хураалтын эцсийн мэдээгээр Улаан буудай- 13291 га-д тариалалт хийж, га-н ургац 11.5 цн, хураах ургац 15284.6 тн, рапс- 2066 га-д тариалж, га-н ургац 5 цн, хураах ургац 1033 тн, малын тэжээл /маалинга/- 40 га-д тариалж, га- 8 цн, хураах ургац 32 тн, арвай- 30 га-д тариалж, га-н ургац 6 цн, хурааж авах 18 тн, овъёос- 25 га-д тариалж, га-н ургац 5 цн, хурааж авах ургац 12.5 тн, төмс 256 га-д тариалж, га-н ургац 120 цн, хурааж авах ургац 3072 тн, хүнсний ногоо 243.6 га-д тариалж, га-н ургац 120 цн, хурааж авах ургац 2923.2 тн тус тус хураан авсан.

Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн ажилтнууд Сайхан суманд 2017 оны 10 сарын 20-ны өдөр худалдаа үйлчилгээний газрын үнэлгээ, жин баталгаажуулалт хийн ажиллалаа. Нийт 8 хүнсний дэлгүүр, 2 нийтийн хоолны газруудад үнэлгээ хийн ажилласан байна.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 0,07 га газар өмчлөх өргөдөл 2017 оны 10-р сарын байдлаар шинээр Дөмбөн хороололд газар хүссэн 6 иргэн, Номгон 3-р багт газар хүссэн 2 иргэн, Ширээ нуруунд газар хүссэн 60 иргэн нийт 68 иргэн шинээр газар өмчлөх хүсэлт албан ёсоор гаргасан бөгөөд өргөдлийг хүлээн авч өргөдөл бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн байна. Газрын харилцаатай холбоотой тодорхойлолт нийт 18 иргэнд олгосон. 2017 оны 10-р сар Засаг даргын захирамжаар нийт 42 иргэнд газрын тухай хуулийн дагуу шинээр газар өмчлүүлж, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газраа өмчилж мэдээллийн санд бүртгүүлсэн 3 иргэн байна. Газрын харилцаатай холбоотой тодорхойлолт 5 иргэнд олгосон. Мөн 2017 оны 10-р сард газраа өмчлөн кадастрын зураг хийлгэн гэрчилгээжүүлэн улсын бүртгэлд бүртгэгдсэн 18 иргэн байна. 2017 оны 10-р сард Сайхан сумын нутаг дэвсгэрт газар эзэмших хүсэлтэй 15 иргэний өргөдөл хүлээн авсан байна. Мөн авто грашийн зориулалттай эзэмшлийн газраа Засаг даргын захирамжаар хэсэгчлэн хуваасан 1 иргэн, грашийн зориулалттай нэгж талбар дээрээ гэрээ байгуулан, гэрчилгээжүүлэн улсын бүртгэлд албан ёсоор бүртгүүлсэн 2 иргэн байна. Банк санхүүгийн байгууллагад эзэмшил газрынхаа гэрчилгээг барьцаалсан, барьцаа бүртгэлд 1 аж ахуй нэгж, 1 иргэн тус тус бүртгэгдсэн байна. 2017 оны 10 сарын 19-ний өдөр Сайхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 1, 2-р багт байршилтай 2 нэгж талбар 80,2 га газрыг Цэгц хараа ХХК нь нарны цахилгаан станцийн зориулалттай, мөн Сайхан сумын ЕБСургууль нь өргөтгөл хийхтэй холбогдуулан хашаагаа тэлэх хүсэлтийг тус тус гаргасан. Дээрх 2 газрын асуудлыг хурлаар оруулан шийдвэрлүүлсэн.

2017 онд аймгаас эрх шилжсэн болон орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр “Зам засвар тэмдэг тэмдэглэгээ” хийх ажил, “Гэр хороолол руу явган хүний зам”-ын ажил, “Номгон тосгоны цэцэрлэгт хүрээлэнг хашаажуулах” ажлууд 100% хийгдэж улсын комисст хүлээлгэж өгөөд байна.

Хөдөлмөр Халамжийн сангаас 10-р сард буюу 3-р улирлын байдлаар халамжийн тэтгэвэр 120 иргэн 133,281,450 төгрөг, асаргааны мөнгөн тэтгэмжийг 77 иргэн 39,185,530 төгрөг, онцгой байдлын мөнгөн тэтгэмжийг 55 иргэн 25,778,760 төгрөг, 1-р одонгийн мөнгийг 123 эх 24,600,000 төгрөг, 2-р одонгийн мөнгийг 300 эх 30,000,000 төгрөг, одонгийн дагалдах мөнгийг 7 иргэн 140,000 төгрөг, жирэмсэн эхийн мөнгийг 180 иргэн 41,816,830 төгрөг, ахмад настны тусламж хөнгөлөлтөнд 123 ахмад 153,238,825 төгрөг, ахмад настны хүндэтгэлд 155 ахмадад 1,550,000 төгрөг, насны хишгийг мөнгийг 199 ахмад 32,800,000 төгрөг, алдар цолтон 3 иргэн 4,490,000 төгрөг, ХБИ-ний тусламж хөнгөлөлтөнд 6 иргэн 983,030 төгрөг, ХБИ-ний протез ортепедын хөнгөлөлтөнд 19 иргэнд 3,765,000 төгрөгийг зарцуулсан. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны баталгаажуулалтын ажил 09 сарын 25 - наас 10 сарын 09-ны хооронд болсон бөгөөд Сайхан суманд 764 өрхийн зөрүүтэй мэдээлэл ирж ажлын хэсэг байгуулан иргэдтэй уулзан тулгалт хийж шуурхай ажилласны үр дүнд зөрчлийг бүрэн арилгаж холбогдох бичиг баримтыг аймгийн ХХҮГ-т хүргүүлээ.

Аймгийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газраас Мэргэжил олгох сургалтаар Гар утасны засварчны сургалтыг Ажилгүй, ажил хайгч иргэдийг хамруулан явуулж, хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт салбар хорооны гишүүдийг чадавхижуулах зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтныг мэргэшүүлэх” сертификаттай сургалтанд хамрагдсан байна. Мөн Хэрэглээний боловсролын төв” ТББ-тай хамтран Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал, зуршил” сэдвээр төр, төсвийн аж ахуй нэгж байгууллагын 150 гаруй ажилтан албан хаагчдын дунд сургалтыг зохион байгуулсан.

Сум дундын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн нэгж нь 10-р сарын тайлангийн хугацаанд нийт 264 мэдүүлэг авч Монгол Улсын үндсэн хууль, Иргэний тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад эрх зүйн актууд

болон дээд шатны байгууллагын чиглэл заавар зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Орхонтуул сум:

Тайлант сард Монгол Улсын Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж үе үеийн сумын ИТХ-ын дарга, Засаг даргаар ажиллаж байсан хүмүүсийг урьж хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Мөн Орхонтуулын мэдээ сонин тусгай дугаарыг бэлтгэн гаргаж иргэдэд хүргэснээс гадна сумын албан ёсны веб сайт болон Facebook хуудсаар дамжуулан иргэдийг мэдээ мэдээллээр хангах ажлыг хэрэгжүүлж байна.

Иргэдийн эрх зүйн мэдлэгийн дээшлүүлэх зорилгоор Зөрчлийн тухай хуулийн мэдээллийг Явуулын иргэний танхим ажиллуулан Хонгор-Овоо 3-р багийн Баянцогтын орчим нутаглаж байгаа 10 гаруй өрхийн гишүүдийг хамруулан зохион байгууллаа.

2017 оны намрын ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэх ажилд шаардагдах машин техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган 10-р сарын 20-ны байдлаар 5054 га-ийн улаан буудайн ургац хурааж 3169,5 тн-ыг, 48,2 га-ийн хүнсний ногоо хурааж 484,3 тн-ыг, төмс 32,0 га-ийн ургац хурааж 313,2 тн-ыг хураан аваад байна. Малчид 5100 тн байгалийн хадлан бэлтгэж нийт бэлтгэх хадлангийнхаа 43,6%-ийг бэлтгэсэн байна. Мөн малчид иргэд өөрсдийн нөөц бололцоог ашиглан 7,5 тн сувлын болон гар тэжээл бэлтгээд байна.

Сумын дүнгээр 2017-2018 оны өвөл, хаврын улиралд 670 цэгт тэмээ 416, адуу 13000, үхэр 18800, хонь 103400, ямаа 72000 толгой буюу нийт 207600 толгой мал өвөлжихөөр бэлтгэл ажлаа хийж малын хашаа, хороо засаж сэлбэх, дулаалах, өтөг бууц нөөцлөх ажлыг хэрэгжүүлж өвс тэжээл, хужир шүү бэлтгэх, нөөцлөх малчдын хувийн бэлтгэлийг хангуулах талаар багуудын малчдаар явж анхааруулах, сурталчиллах ажлыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/368 тоот захирамжийн дагуу сумын Засаг даргын А/110 тоот захирамж гарган сумын Мал эмнэлэг үржлийн нэгжүүд адуунаас бусад малын төлд бруцеллёзоос урьдчилан сэргийлэх вакцин тарилгыг 5800 толгой тугал, 46662 толгой хурга, ишигт 2017 оны төлөвлөгөөт вакцинжуулалтын ажлыг хийснээс гахайн мялзангийн вакцинныг 500 гахайд, бог малын угаалга 72000 толгойд, туулгалтын ажлыг 109,0 толгой малд хийгээд байна. 2017 оны мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд өссөн дүнгээр боомын вакциныг 24735, цусан халдвартын вакциныг 3977 малд, шөвөг ярын вакциныг 8500, дуут 7000, ДХХ 3716, сахуу 1270, сохор доголын вакциныг 5386 толгой малд хийж халдварт өчнөөс урьдчилан сэргийлэх вакцинныг хийж гүйцэтгэлээ.

2017 оны гэрээнд тусгагдсаны дагуу үхэр ангилалтын ажлыг хэрэгжүүлэн 2017 оны 10-р сарын 20-ны байдлаар 560 толгой үхэрт ангилалт үзлэг хийгээд байна.

Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг суманд үйл ажиллагаа явуулж байгаа гурван МЭҮН-д гүйцэтгэн нийт 54 өвөлжөө хашааг ариутган халдваргүйжүүлсэн ба мөн өтөг бууц 60-тн ариутгасан энэ арга хэмжээг цаашин үргэлжлүүлэн 10-р сард багтаан үлдсэн өвөлжөө хашааг ариутгахаар төлөвлөн ажиллаж байна.

Сумын малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах, эр сувай мал, өвөл хаврын улиралд эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж дунд ба дундаас доош тарга хүчтэй малыг оторлон бэлчээрээр тарга хүч авахуулан маханд борлуулах ажлыг зохион байгуулж 2017-оны 11-р сард хэрэгцээжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Сумын мал сүрэгт шаардагдах хүчит тэжээлийг сум орон нутагт газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудаас зохих хувийг хангуулах талаар гэрээлэн одоогоор 160 тн өвс 20 тн тэжээл авахаар тохиролцоод байна.

Мөн аймгийн Засаг даргын ивээл доор зохион байгуулагдсан “Сэлэнгийн ногоон өдрүүд 2017” үзэсгэлэн худалдаа, ногоочдын зөвлөгөөнд тус сумаас 3 ногоочин оролцож ургацын дээжээс үзэсгэлэн худалдаанд оролцлоо.

Швецарийн хөгжлийн агентлагаас зохион байгуулж байгаа “Ногоон алт” хөтөлбөрийн ач холбогдол цаашдын үйл ажиллагааны чиглэлийн талаар малчдад сурталчилах гарын авлага материал тараан цаашид уг үйл ажиллагаанд оролцох чиглэл аргачлалын талаар сурталчилан ажиллалаа. Сумын Засаг даргын Тамгын газар Монголын чанарын удирдлагуудын зөвлөхүүдийн холбооны ахлах зөвлөхтэй хамтран сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын дагуу Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх ажлыг эхлүүлэн 2 дахь удаагийн зөвлөх үйлчилгээг аваад байна.

Тайлант хугацаанд БОАЖ-наас өгсөн зөвшөөрлийн дагуу тус суманд “Эко петролиум” ХХК 1 тн, “Арвижих бизнес” ХХК 1 тн, “Бурхантын жинчид” ХХК 1,5 тн нийт 3,5 тн байгалийн ургамал түүж бэлтгэх ажилд хяналт тавьж ажиллалаа. Бүх нийтийн их цэвэрлэгээ аяны хүрээнд иргэдийг хогийн төвлөрсөн цэгт ахуйн хог хаягдлаа зөв зохистой хаяж хэвшүүлэх зорилгоор Баянцогт 2-р багийн Бор толгой хорооллын 19 өрхийн иргэд хогийн цэгийн гадуур асгасан хог хаягдлыг булж, шатаах болон хашааг нь засч сэлбэх ажлыг хийсэн байна.

Сумын орлого бүрдүүлэх зорилгоор өртэй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өрийн тооцооллыг гарган өр барагдуулах шат дараалсан арга хэмжээг удаа дараа авч хэрэгжүүлэн 8 аж ахуйн нэгжийн 45900,0 төгрөгийн мэдэгдэл хүргүүлснээс 8,100,000 төгрөгийг оруулсан байна. Татварын төлөгчөөр шинээр 2 хүнд бүртгүүллээ. Галт зэвсгийн албан татварын өртэй иргэдийн өрийн тооцооллыг гаргаж нийт татвар төлөгчдийг бүртгэх ажлыг сумын хэсгийн төлөөлөгчтэй хамтран гүйцэтгэж байна.

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч, даатгуулагчаас 10-р сарын 25-ны байдлаар 4282,8 мянган төгрөгийн шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 565,4 мянган төгрөгийн хураамжийн орлого оруулж, өндөр насны тэтгэвэрт 359 хүнд 103308,8 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 110 хүнд 25374,4 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 23 хүнд 5214,37 мянган төгрөг, цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр 1 хүнд 377,0 мянган төгрөг, цэргийн өндөр насны тэтгэвэрт 1 хүнд 597,72 мянган төгрөг, нийт 134872,42 мянган төгрөгийг хугацаанд нь олгосон.

Баруунбүрэн сум:

Монгол Улсын Засгийн газрын 186-р тогтоол, аймгийн Засаг даргын 04 тоот албан даалгавар, ХХАА-н сайдын 01 тоот албан даалгаврын биелэлт, мал өвөлжилтийн болон ургац хураалтын мэдээ тайланг маягтын дагуу гаргаж холбогдох газарт нь хүргүүлж, сумын ИТХ-ын тэргүүлэгчдэд танилцууллаа.

“Гацуурт” ХХК-д үржүүлж буй махны хэвшлийн улаан ангус бяруун бухнаас аймгийн ХХААГ-ын хуваарийн дагуу 4 бух авчирч малчдад тараан өгсөн. Малын ашиг шимийн судалгааг гаргаж аймгийн ХХААГ-т хүргүүлсэн.

Том малын хорогдол болон төл бойжилтын мэдээг сар бүр гаргаж аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлж байна. Одоогоор сумын хэмжээнд 60955 толгой хээлтэгч төллөснөөс ингэ 3, гүү 2450, үнээ 3900, эм хонь 33860, эм ямаа 20742 толгой төллөсөн байна. Төлийн хорогдол 1463 байгаагаас унага 123, тугал 120, хурга 540, ишиг 680 толгой хорогдсон байгаа ба бойжиж буй төл 59492 толгой байгаагаас ботго 3, унага 2327, тугал 3780, хурга 33320, ишиг 20062 байна. Том малын хорогдол 2246 байгаа ба үүнээс адуу 180, үхэр 405, хонь 781, ямаа 880 толгой тус тус хорогдсон байна.

Сумын хэмжээнд золбин нохойны устгалын ажлыг Ц.Бямбасүрэн ахлагчтай “Устгах ажиллагаа” бүлэг нийт 64 нохойг устгаж ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажиллалаа.

“Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлыг хамгаалах, ойн тогтвортой менежмент, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх” төслөөс нөхөрлөлүүдийн үйл

ажиллагааг дэмжиж нэг нөхөрлөлд 5га талбайд арчилгааны ажил хийх санхүүжилт өгсөн. Энэ ажлын дагуу ойн анги нь Баруунбүрэн сумын Бүрэн тоонч, Бүрэн төгөл, Байгалийн хишиг, Ногоон сан, Түвшинбүрэн, Далт, Бумбат хангай, Сант сумын Хан хушаат, Алтансүмбэр, Ноёны бууц зэрэг төсөлд хамрагдсан 10 нөхөрлөлд арчилгааны ажлаар 50 га талбайд талбай тусгаарлалтын ажлыг хийлээ. Мөн БОАЖЯ, ОСХТ-өөс нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд нэг нөхөрлөлд 1000000 төгрөгний санхүүжилт өгч ойн анги нь цэвэрлэгээний ажлаар нийт 40 га талбайд талбай тусгаарлалтын ажлыг хийлээ.

Монгол Улсын ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, 2013 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 178 дугаар зарлиг, БОАЖ-ын Сайдын 2017 оны А/83 тоот албан даалгавар, Сэлэнгэ аймгийн Засаг Даргын А/407 тоот захирамжийг үндэслэн “Бүх нийтээр мод тарих” ажлыг зохион явуулаа. Бүх нийтээр мод тарих ажилд тус сумын ЗДТГазар, ЭМТөв, ЕБСургууль, 25-р цэцэрлэг, “Ник” ШТС, “МТ” ШТС, Хаан банк, Төрийн банк, Ойн анги болон ЕБС-н сурагчид зэрэг төр төсвийн байгууллагын ажилчин албан хаагчид оролцож, хайлаас 160 ширхэг, бөөрөлзгөнө 260 ширхэг, агч 230ш нийт 650 ширхэгийг сумын төв замын хар зам дагуу тарьж, мод тарисан хашааны хогийг цэвэрлэн, усалгаа хийлээ.

Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсээс холбогдох мэргэжилтэнгүүд ирж хугацаа дууссан хилийг баталгаажуулахаас гадна тохиролын гэрчилгээ дууссан дэлгүүрүүд дээр үнэлгээ дүгнэлт хийж тохиролын гэрчилгээний сунгалтыг хийж, 7 дэлгүүр, нэг байгууллага хамрагдлаа.

Төсөвт байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн санхүүгийн болон мэргэжлийн зөвөлгөө арга зүйн дэмжлэг үзүүлж төсвийг хэмнэлттэй оновчтой, зориулалтын дагуу зарцуулах, төсвийн өр авлага үүсгэхгүй байх зорилт тавин ажиллаж байна. Төрийн санд 2017 оны 10 дугаар сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого төлөвлөгөөгөөр 77967.6 орохоос гүйцэтгэлээр 88083.7 мянган төгрөг орж биелэлт 112.9 хувийн биелэлттэй байна. Туслах үйл ажиллагааны орлого болон үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөгөөгөөр 31323.5 мянган төгрөг орохоос гүйцэтгэл нь 26242.1 мянган төгрөг орж биелэлт 83.8 хувьтай байна. Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт төлөвлөгөөгөөр 1144735.6 мянган төгрөг ирэхээс 1144735.6 мянган төгрөг ирж гүйцэтгэл нь 100% санхүүжигдсэн. Зардлын гүйцэтгэл нь 931814.1 мянган төгрөг байна.

Орон нутгийн санхүүгийн дэмжлэгт төлөвлөгөөгөөр 232423.1 мянган төгрөгийн санхүүжилт ирэнхээс бүрэн хийгдсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт төсвөөс санхүүжих нь төлөвлөгөөгөөр 83589.2 мянган төгрөг ирэхээс гүйцэтгэлээр 79396.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 59600.5 мянган төгрөгийг зарцуулсан.

Мал эмнэлэгийн үйлчилгээний санхүүжилт 25986.0 мянган төгрөгөөс 3 мал эмнэлэгийн вакциныг хариуцсан багийн малчдаар явж хийх зардалд 14746.3 мянган төгрөгийг олгоод байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн өндөр дадлага туршлагатай 5 ахмад настан шатар, эрүүл мэндийн зөвлөгөө, сувсан хэлхээ, монгол бичиг, угийн бичиг хөтлөх талаар сургалт зөвлөгөөг одоогийн байдлаар эхлүүлээд байна.

Олон Улсын ахмадын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Амарбаясгалант хийдийн Дархан хамба асан аав Т.Жамъяндагвын үр хүүхдүүд хүндэтгэлийн цайллагыг зохион байгуулж, 220 гаруй ахмад оролцсон. Энэ арга хэмжээнд ЕБС-ийн сурагчид, Дархан уул аймгийн Хүүхэд Залуучууд театрын уран бүтээлчдийн урлагын тоглолт болж, сумын аж ахуйн нэгж байгууллагууд ахмадууддаа хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа. Мөн Улаанбаатар хотын “Бүрэн хан” эмч нарын холбоо, сумын эрүүл мэндийн төв хамтран дотор, зүрх судас, эмэгтэйчүүд, уламжлалт, чих хамар хоолой, эхо, хүүхдийн нарийн мэргэжлийн эмч

нарын үзлэгийг 9-р сарын 30, 10-р сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулж, давхардсан тоогоор 245 иргэд хамрагдаж зөвлөгөө авлаа.

Сумын ахмадуудын дунд “Сүрьеэг бууруулахад настны оролцоо”, “Настны эрүүл мэнд” ярилцлага, “Артерын даралт”, “Чихрийн шижин” өвчний мэдлэгийг дээшлүүлэх түүнээс урьдчилан сэргийлэх талаар 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр сумын ЭМТ-н эмч нар ахмадын байранд сургалт, сурталчилгаа хийлээ. Тус сургалтанд сумын “Ахмадын холбоо”-ны ахмадууд идэвхи санаачлагатай оролцож сургалтаар “Артерын даралт”, “Чихрийн шижин”, “Сүрьеэ” өвчнөөс яаж урьдчилан сэргийлэх, энэ өвчнүүдийн үед ямар шинж тэмдэг илрэх, онцлог шинжүүд, хүндрэл, манай орны хувьд ямар насны иргэд илүүтэй өвчилдөг болон өвчилсөн тохиолдолд авах арга хэмжээ, дэглэм яаж баримтлах, ямар эрхтэн тогтолцоонд өөрчлөлт гардаг талаар мэдээлэл, сургалт хийж ажиллаа.

Сумын эрүүл мэндийн төв тайлант сард амбулаторийн үзлэг 156, урьдчилан сэргийлэх үзлэг 103, осол гэмтлийн 8, шээс, цус, цагаан хорхой, дох бэлгийн замын өвчлөлийн шинжилгээнд 48 иргэнийг хамруулж, 27 иргэнийг хэвтүүлэн эмчилж, 1, 2, 3-р багийн зорилтот бүлгийн 6 сараас 59 сартай нийт 83 хүүхдэд гэрийн эргэлт хийж өндөр, жин, булгалгын тойрог үзэж олон найрлагат бичил тэжээлийн холимогийг 2-р ээлжний давтан тунг тарааж өгсөн. Мөн өндөр настан, жирэмсэн, 0-5 насны хүүхдэд гэрийн эргэлтийг давхар хийж зөвлөгөө өгч ажиллаа.

Элэгний В, С вирусын шинжилгээнд тус сумын нийт 510 хүнээс вирустай гарсан 123 хүний сорьцыг Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторит зөөвөрлөн шинжилгээнд хамруулснаас эхний ээлжний 60 хүний хариу ирсэн бөгөөд шаардлагатай хүмүүсийг эмчилгээнд хамруулж 2-р шатны эмэндээ хамрагдаж эмээ ууж байна. Үлдсэн 63 хүний шижилгээний хариу ирээгүй одоогоор хүлээгдэж байна.

2017 оны 10-р сарын 07-ны өдөр “Дэлхийн алхалтын өдөр”-ийн хүрээнд ЗДТГ ажилчид, 25-р цэцэрлэгийн багш, ажилчид, ЕБС-ийн багш, ажилчдад ажлын байранд дасгал хөдөлгөөн хэрхэн хийх талаарх сургалт зохион байгуулж заасан ба нийт 100 хүн хамрууллаа. Үүнд: ЗДТГ-ын 12 ажилчид ажлын байрны дасгал, ЕБС-ын 13 багш, 40 сурагчдад ажлын байрны дасгал, 25-р цэцэрлэгийн 35 багш ажилчдад ажлын байрны дасгал, артерийн даралт багасгах дасгал хийж өдөр бүр ажлын байранд хийж хэвших зэрэг заавар зөвлөгөө өглөө.

Аймгийн иргэдийн хурлын тэргүүлэгчдийн 38 дугаар тоот тогтоолын дагуу “Сэлэнгэ нутгаа” алдаршуулах түүх соёлыг таниулах зорилгоор “Сэлэнгэ минь” шүлгийг чээжлүүлэн уран тодоор уншуулах аянд 1-12-р ангийн 506 суралцагчид хамрагдаж анги хамт олноороо идэвхтэй оролцлоо.

Дэлхийн багш нарын 23, Монголын багш нарын 51 дэх өдрийг тохиолдуулан дунд спортын 3-н төрлийн тэмцээн, сурагчийн нэг өдөр арга хэмжээ, “Үе үеийн багш нараасаа суралцъя” дурсамж хичээлийг зохион байгуулснаас гадна баярын хурлыг зохион байгуулсан.

Сургуулийн намар цагийн соёл хүмүүжлийн ажлын нээлтийн үеэр спортын спартакиадыг насны ангилалаар 4-н төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 600 гаруй сурагчид хамрагдсан байна.

Тайлант сард цэцэрлэгийн хүүхдийн ирц бүрдэлт 80.7%-тай байна. Бэлтгэл, ахлах, дунд “А”, “Б” бүлгийн хүүхдүүд явган аялал хийж сумын газар тариалан эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн бригадаар аялан үйл ажиллагаатай танилцан ажиллаа. Бага “А”, “Б” бүлгийн хүүхдүүд ангидаа алтан намараа тэмдэглэн өнгөрүүлээ.

Шаамар сум:

Аймгийн Засаг даргын 2017 оны 04 тоот албан даалгавар, сумын Засаг даргын А/34 тоот захирамжаар сумын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, сум, тосгоны өвөлжилтийн бэлтгэл ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, хүлээн авах ажлын хэсгийг байгуулж холбогдох ажлын салбар комиссуудад үүрэг чиглэл өгөн өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Малчин, мал бүхий иргэдээр хадлан бэлтгүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг хуралдаж сумын иргэд болон Сүхбаатар сумын иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, хүсэлтийг хэлэлцэн шинээр хадлангийн газар хүссэн 9 иргэнд өгсөн. Энэ сарын 10-ны байдлаар 437 иргэн хадланд гарч 5000 тн хадлан бэлтгэсэн байна. Газрын маргаантай байсан 42 иргэний газрын асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. Сумын өвсний фондод 800 боодол, 1 машин задгай өвс нийт 22 тн өвс нөөцөлсөн байна. Сумын хэмжээнд малчин мал бүхий 120 өрхөд хүнсний ногооны масс иш, хаягдал ногоогоор 26 тн дарш, сүрэл 800 боодол, халгай, аг мангир, модны навч зэрэг ургамалаар 300 кг гар тэжээл, Увс аймгаас давс 15 тн, Цагааннуурын хужир шүү 10 тн, хүчит тэжээл 19 тн, будааны хаягдал 10 тн татан авч бэлтгэсэн байна.

Сумын Мал эмнэлэг, үржлийн 3 нэгж үйл ажиллагаагаа хэвийн явуулж малчдад мал сүргийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг бод 13890 толгой малд, малын угаалгыг 9500 бог малд хийж дуусгасан. Бруцеллёзийн вакцин 5846 толгой төл мал, Боомын вакцин бод 5100, бог 11650 толгой, Ариутгал халдваргүйжүүлэлт зөгийний өвөлжөө 1471 м², хашаа зоорь, малын өвөлжөө 6296 м², туулгалтанд бод 5400, бог 6100 толгой малд хийгээд байна. 3-р улиралын байдлаар мал эмнэлэг, үржлийн нэгжийн эмч нарт нийт 88 дуудлага ирснийг хүлээн авч үзлэг явуулж, оношилгоо эмчилгээ хийсэн байна. Малчдад гар тэжээл бэлтгэх, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлагын зөвлөмжийг 50 гаруй малчин өрх, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, халдварт өвчний тандалт үзлэгийг 28 суурийн 250 толгой малд хийлээ. Хүнс хөдөө аж ахуйн яамны санхүүжилтээр малыг чанаржуулах, мах сүүний чиглэлийн АНГУС үүлдрийн цэвэр 4 бухыг сумын 3 багийн 1 мал эмнэлэг үржлийн нэгж, 2 үхрийн фермерийн аж ахуй эрхлэгч, 1 иргэнд хүлээлгэн өгсөн.

Ургац хураалт үр тариа 1301 га-аас 1136 тн ургац, рапс 653 га-аас 326 тн, төмс 90,4 га-аас 1012 тн ургац, хүнсний ногоо 195,3 га-аас 2504,5 тн ургац, жимс 11 га-аас 5,6 тн хураан авсан.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Охиндий 2-р багийн “Баясгалант Ирээдүй” 2-р цэцэрлэгийн гаднах хашаа тоглоомын талбайн ажил, Замын тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлэгийн ажлыг “Наранбулаг” ХХК 100% гүйцэтгэж улсын комисс хүлээн авлаа. Мөн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар Охиндий 2-р багт Хүүхдийн тоглоомын талбай барих ажлын тендэр шалгаруулалтын ажлыг зохион байгуулж “Энх багана” констракшинтай шууд гэрээ байгуулж барилгын ажил эхэлсэн.

Дэлхийн багш нарын 23 жил, Монголын багш нарын 51 жилийн ойг Шаамар сумын сургуулиуд, цэцэрлэгийн багш нар тэмдэглэж, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгууллаа. Энэ үеэр амжилт гаргасан шилдэг тэргүүний багш нарт төрийн шагналуудыг гардуулан өгөх хүндэтгэлийн ёслол болов. Сумын хэмжээнд 186 багш төрийн өмчийн сургууль цэцэрлэгт ажиллаж байна.

Цэргийн жинхэнэ албаны ээлжит татлагыг зохион байгуулах хуваарь батлагдсаны дагуу сумын 18-25 насны цэргийн жинхэнэ алба хаах насны эрчүүдийн судалгааг шинэчлэн зарлан дуудах хуудсыг нийт 136 иргэнд хүлээлгэн өгсөн. Хуваарьт хугацаанд нийт 61 албанд татагдагсдыг товлосон газарт эрүүл мэндийн үзлэгээр оруулж цэргийн жинхэнэ албанд тэнцсэн 5 иргэний зохих материалыг бүрдүүлэн холбогдох шинжилгээнд хамруулан хүлээлгэн өгсөн.

Ойн тухай хууль, Амьтны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль зэрэг хуулийн хэрэгжилтийн хүрээнд эргүүл хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж сумын нутаг дэвсгэр Орхон голын гүүр орчимд Цагдаагийн алба хаагч болон Байгаль хамгаалагчийн хамтаар шөнийн цагаар нийт 12 удаа хийсэн. Эргүүл хяналт шалгалтанд 60 гаруй иргэн, 22 тээврийн хэрэгсэл хамрагдсан ба үзлэг хийхэд зөрчил дутагдалгүй тайван байв. БОАЖЯ-наас байгалийн ургамал түүж бэлтгэх зөвшөөрөл авсан “Алтан ойл ХХК” компанитай 1 тонн Дэрэвгэр жиргэрүү түүх гэрээ байгуулан

10,000,000 төгрөгийн төлбөрийг төлүүлж зүй зохистой түүж бэлтгэх, хог хаягдал гаргахгүй байх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулсан.

Нийгмийн даатгалын сангийн тайлан тэнцэлээр: 2017 оны 10 сарын тайлан тэнцэлээр 23 ажил олгогч, 199 даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэл төлж, сайн дурын даатгалд шинээр 3 хүн хамруулж нийт 215 даатгуулагчийн шимтгэлийг сар болон улирлаар төлүүлж, нийгмийн даатгалын дэвтэр болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрийг тухай бүр нь баталгаажуулан ажиллаж байна. Тэтгэмжийн даатгалын сангаас: жирэмсэн амаржсаны тэтгэмж 1 хүнд 1,050 сая төгрөг, оршуулгын тэтгэмж, 1 хүнд 1 сая төгрөг, 9 хүнд ажилгүйдлийн тэтгэмж 3,400,000 төгрөг тус тус олгож ажиллалаа.

“Эерэг хандлага-эрүүл оюутан” аяны хүрээнд оюутан залуучуудыг эерэг хандлагад уриалж, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх арга замын талаар сурталчлан таниулах зорилгоор МСҮТ-ийн оюутан сурагчдын дунд “Хорт зуршил” сэдэвт сургалтыг 2017 оны 10 сарын 18-ны өдөр дотуур байрны номын санд зохион байгуулж нийт 40 гаруй оюутан сурагчид хамрагдлаа.

Хүдэр сум:

Тайлант сард сумын Засаг даргын зөвлөл 3 удаа хуралдаж сумын нийгэм, эдийн засгийн 2017 оны үндсэн чиглэлийн биелэлт, 2018 оны үндсэн чиглэлийн төсөл, өвөлжилтийн бэлтгэл байдал, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил, ургац хураалтын талаархи мэдээлэл сонсголууд болон цаг үеийн зарим асуудлыг хэлэлцсэн.

Сумын хэмжээнд 2017 онд хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудын талаарх мэдээллийг “Хүдэрийн мэдээ” сонинд хэвлүүлж, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд мэдээллээ.

Нийгмийн хариуцлагын гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Эрдэс Холдинг” ХХК-ий хөрөнгө оруулалтаар махны дэлгүүрийг ашиглалтанд оруулснаар эрүүл ахуйн шаардлага хангасан мах худалдаалах боломж бүрдсэн.

Сум орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг худалдаа үйлчилгээний газруудад шавьж устгалын ажлыг аймгийн “Ариун таван хаан” ХХК-тай хамтран зохион байгууллаа.

Хүдэр голын сав газрын зөвлөл, Чоно голын эзэн ТББ-тай хамтран Нуурын тагт, Монгол алт, Амж чиглэлд зохих зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлож буй уул уурхайд хяналт шалгалт хийж техник тоног төхөөрөмжөө татан буулгах албан мэдэгдэл өгсөн. Тус суманд зохих зөвшөөрөлгүй хууль бусаар алт олборлож байгаа аж ахуй нэгж байгууллага, иргэдийн үйл ажиллагаанаас болж Хүдэр гол их хэмжээгээр бохирдож байгаатай холбоотой дээрх хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, арга хэмжээ авч аймгийн Цагдаагийн газрын хэрэг бүртгэх тасгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Амж, Нуурын тагт, Монгол алт чиглэлд хууль бусаар үйл ажиллагаа явуулж байгаа иргэд тогтоосон хугацаанд техник тоног төхөөрөмж, хүн хүчээ буулгаагүй аж ахуй нэгж, иргэдийг албадан буулгаж, хуулийн дагуу хариуцлага тооцон ажиллаж байна.

“Хасмарк” ХХКомпани 37 иргэн 1 аж ахуйн нэгжийн кадастрыг хийж мэдээлэлд оруулан газрын төлбөрийн орлогын шахан 11432,0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

Татварын орлогын төлөвлөгөө 36324.6 төгрөг гүйцэтгэл 90846.0 хувь 250 биелэлтэй ажиллаж байна. Үүнээс орон нутгийн орлогын төлөвлөгөө 14693.4 гүйцэтгэл 78531.0 хувь 535 аймгийн орлогын төлөвлөгөө 17605.0 гүйцэтгэл 9158.2 хувь 52 улсын төсвийн төлөвлөгөө 4026.2 гүйцэтгэл 3156,8 хувь 78.3 биелэлтэй. “Хүдэр мөнгөлөг” ХХК, “Хүдэр Цээл” ХХК, “Хүдэр өсөх” ХХК, “Хангайн буудай” ХХК, “Зочин Хад” ХХК, “Хүдэр од трейд” ХХК, “Ник” шатахуун түгээх станц, ЭМТ-ийн эргэлтийн эмийн сан, “Үзэсгэлэнт Хүдэр” ХХК-ний дэлгүүр, шатахуун түгээх станц нь ebarimt хэвлэн өгч байна. Татварын бааз суурь сар бүр нэмэгдэж байгаа энэ сарын байдлаар 135 аж ахуй нэгж суманд бүртгэлтэй үүнээс 48 аж ахуй нэгж үйл ажиллагаа

тогтмол явуулж байна. Галт зэвсгийн албан татварын хэрэгжилтийг хангахаар сайтар анхааран ажиллаж байна. Өмнөх оны өрөөс 5713,0 төгрөгийг барагдуулж аймгийн төсөвт төвлөрүүлэн ажиллав.

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг 54 иргэнд үзүүлж, 29 даатгуулагчийн 756,980 төгрөгийн шимтгэлийг эрүүл мэндийн даатгалын санд оруулж, сайн дурын даатгалд 2 даатгуулагч шинээр даатгуулсан

Аймгийн Эрүүл мэндийн газраас хяналт үнэлгээний баг орон нутагт ажиллаж, эрүүл мэндийн төвийн эмч нарт мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажиллалаа. 10-р сард эрүүл мэндийн төвөөс амбулаторын 163 үзлэгийг хийж, 0-15 настай 173 хүүхдийг дархлаажуулалтанд хамруулсан. Мөн ЕБС-ийн 10, 2-р ангийн нийт 126 хүүхдэд 2 вакциныг, 15 настай 42 хүүхдэд Улаанбурхан өвчний эсрэг вакциныг, Улаанбурханы вакциныг 6 сартай 5 хүүхдэд хийж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн талаар зөвөлгөө өгч ажилласан. “Сүрьеэг бууруулахад настны оролцоо” сэдэвт арга хэмжээг зохион байгуулж 120 ахмад настан хамрагдаж, жүжигчилсэн тоглолт, дасгал хөдөлгөөн хийж иргэдэд сонирхууллаа.

2017-2018 оны хичээлийн жилд ЕБС-ийн 22 бүлэгт 533 сурагч суралцаж, сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулан явуулж байна. Жил бүр уламжлал болгон зохиогддог сурган хүмүүжүүлэх уншлагын уралдаан, “Номын баяр”, “Хуруу хүүхэлдэй” жүжигчилсэн тоглолт, IX-XII ангийн сурагчдын дунд “Хүдэр нутгийн бахархал” нэртэй “Дэлгэмэл ном” хийх уралдаануудыг амжилттай зохион явуулсан.

Дэлхийн багш нарын 23 дахь, Монголын багш нарын 51 дэхь удаагийн баярын өдрийг тохиолдуулан “Хишиг өдөр” үйл ажиллагааг 12-р ангийнханы дунд амжилттай зохион байгууллаа.

Сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын цэцэрлэг орон нутгийн дүр төрхийг агуулсан үзэл баримтлал, сургалтын хөтөлбөрийг боловсруулан бүлгийн багш нар сургалтын сэдэв, задаргаа интегралчлал сургалтын хуваарийг хамтран боловсруулж 10/1-10/31-ний хооронд дунд бүлэг таван хошуу мал ахлах бүлэг- гэрийн тэжээвэр амьтад, бэлтгэл бүлэг- шувууд сэдвүүдээр хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Хүүхдийн хийсэн бүтээлээр болон эцэг эхчүүдтэй хамтран Баян намар, Амьтдын ертөнц зохиомжит бүтээлийн үзэсгэлэн гаргаж хүүхэд өөрийн хийсэн бүтээлээр бахархах, бүтээлээ тоглоом болгон ашиглах боломж бүрдүүлсэн. Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийг хөгжүүлэхэд эцэг эх олон нийтийн оролцоо хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор энэ сарын 4-ний өдөр эцэг эхийн өдрийг зохион байгуулж, цэцэрлэг дэх өдөр тутмын үйл ажиллагаа, сургалтын орчны тохижилт, эцэг эхийн болон орон нутгийн оролцоо дэмжлэгээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг танилцуулж суртчилсан байна.

Сүхбаатар сум

Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас хуваарийн дагуу шуурхай хуралдааныг 2 удаа хуралдуулж, хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр зохион байгуулан ажиллалаа.

Талант сард Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний 25 жилийн ойг угтаж сумын ИТХ, сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Иргэдээ сонсьё” аяныг зохион байгуулж, 8 багийн 300 гаруй иргэдтэй уулзаж, санал хүсэлтийг нь сонсож шийдвэрлэх боломжтой зарим асуудлыг шийдвэрлэн ажилласан.

Орон даяар зохион байгуулагдсан цэргийн жинхэнэ албаны ээлжит татлагын эмч нарын үзлэгээр сумын цэргийн насны залуучуудыг оролцуулах арга хэмжээ авч 325 иргэн үзлэгт орсноос 12 иргэн цэргийн албанд мордлоо.

Намрын ургац хураалтын ажил дуусч сумын хэмжээнд 75 га-гаас 1400 тн төмс, 57,2 га-гаас 1100 тонн хүнсний ногоон хураан авсан бөгөөд аймгийн “Ногоочдын зөвлөгөөн”-д 15 ногоочинг хамруулсан. Үүнээс гадна сумын Засаг даргын Тамгын газраас жил бүр уламжлал болгон зохион баайгуулдаг “Шинэ ургац-шилдэг санаа” үзэсгэлэн худалдааг Партизаны талбайд 6 дах жилдээ зохион байгуулж, 8 багийн 70 гаруй төмс, хүнсний ногоо тариалагч иргэд 33 нэр төрлийн хүнсний ногоо, 34 нэр

төрлийн нөөшилсөн бүтээгдэхүүн, 19 нэр төрлийн цагаан идээ, 15 нэр төрлийн мод бутны суулгац, 20-иод нэр төрлийн жимс жимсгэнээр хийсэн бүтээгдэхүүнээр оролцоо. Энэ үеэр иргэдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 12 номинацаар байр эзлүүлэн шалгаруулж, сумын түүхт 80 жилийн ойн хүрээнд ногоон байгууламжийг бодитой нэмэгдүүлсэн айл өрхөө манлайлан үлгэр дууриал болж буй эко, эрүүл орчин бүрдүүлсэн иргэдийг шалгаруулж “Эко өрх” батламжийг гардуулсан.

Тайлант сард аймгийн Засаг даргын Тамгын газар, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулсан 4 талт түншлэл хөтөлбөрийн уулзалтанд төрийн албаны болон иргэний нийгмийн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл 22 хүнийг хамруулснаас гадна мөн хөтөлбөрөөс хэрэгжих “Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих” төслийн хүрээнд тус аймагт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийн судалгааг гарган аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Мөн АНУ-ын Олон улсын Хөгжлийн Агентлаг REACH төсөлтэй хамтран “Таны бизнесийг танд” нэртэй ажил хэрэгч уулзалтыг жижиг дунд бизнес эрхлэгчдийн дунд зохион байгуулж, худалдаа үйлчилгээний салбарын 40 хүн оролцсон. Арга хэмжээнд оролцогчдын 90 гаруй хувь нь борлуулалтын 5-6 сувгийг шинээр нэмэгдүүлж чадсан байна.

Өрхийн амьжиргааны түвшингийн судалгаанд хамрагдсан мэдээлэл зөрүүтэй өрхүүдийн мэдээллийг баталгаажуулах ажлыг 9-р сарын 25-аас 10-р сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 1945 өрхийн баталгаажуулалт хийгдэхээс 1891 өрхийн мэдээллийг баталгаажуулсан.

Тайлангийн хугацаанд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг цаг хугацаанд нь олгож, хүнсний эрхийн бичигт 8 багийн 286 өрхийн 886 том хүн, 794 хүүхэд хамрагдаж байна.

Ахмад настны зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд монгол хэл-бичиг, гадаад хэл, хөдөө аж ахуйн мэргэжил, эрүүл мэнд, дасгал хөдөлгөөний чиглэлээр зөвлөгөө өгөх 4 ахмад настанг хөтөлбөрт хамруулан сургалтыг эхлүүлсэн. Мөн “Гоо урлал” сургалтын төвтэй хамтран сумын 20 иргэнийг оёдол эсгүүрийн 14 хоногийн сургалтанд хамруулах арга хэмжээ авлаа.

Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнууд хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор төв талбайн цэцэрлэгт хүрээнд 200 ширхэг монос, 200 ширхэг шар хуайс, 200 ширхэг хайлаас тарилаа.

Жавхлант сум:

Төр, төсвийн байгууллага, албан хаагчдаас ажлын нэгдсэн төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллалаа.

Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үүднээс сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг хөдөөгийн малчин өрхүүдээр ажиллаж цаг үеийн тулгамдсан асуудал, мэдээ мэдээллийг хүргэхийн зэрэгцээ эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг 195 өрхөд үзүүлсэн.

Сумын хэмжээнд нийт 5870 га-д улаан буудай, 1711 га-д тосны ургамал, 64 га-д төмс, 141 га-д хүнсний ногоо, 80 га-д малын тэжээлийн ургамал тариалснаас ургац хураалтын эцсийн мэдээгээр улаан буудай нэгж га талбайгаас 15,8 цн буюу нийт 9296 тонн, тосны ургамал 235 тн, тэжээлийн ургамал 120 тн, төмс 815 тн, хүнсний ногоо 1710 тонныг хураан аваад байна.

Тус суманд 2017-2018 онд хонин толгойд шилжүүлснээр 182,2 мянган толгой мал өвөлжих бөгөөд 6372 тонн хадлан бэлтгэж, шөвөг яр, дотрын халдварт хордлого, дуут, галзуу, боом, сохор догол өвчнийн вакцинуудыг хийлээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу Ерөө бүсийн сум дундын ойн ангийн дэмжлэгтэйгээр төр, төсвийн байгууллагуудын төрийн албан хаагчид Хавтгай нарсанд 1,2 га газарт 2800 ширхэг мод тарьсан.

Аймгийн төвд зохион байгуулагдсан “Ногоочдын зөвлөгөөн”-д тус сумын 16 ногоочин оролцсон.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэх зорилгоор иргэдтэй уулзан хугацаатай мэдэгдэл өгсөн ба 28 иргэний материалыг бүрдүүлэн шүүхийн эвлэрүүлэн зуучлах албанд өглөө.

Орон нутгийн татварын орлого 9 дүгээр сарын байдлаар 20129,7 мянган төгрөг орохоос 61200,0 мянган төгрөгийг оруулж, 304,0 хувийн биелэлттэй, аймгаас авах орон нутгийн санхүүгийн дэмжлэг 182828,4 мянган төгрөг, тусгай шилжүүлгийн байгууллагууд 756146,5 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангаас 4 мало эмнэлэгт 10212,0 төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Монголын ахмадын баярыг тохиолдуулан сумын ахмад буурлуудад хүндэтгэл үзүүлж, 120 ахмад настан хамрагдсан. Баярын үеэр хүнс, хөдөө аж ахуйн тэргүүний ажилтнаар 3, аймгийн ИТХ-ын өргөмжлөлөөр 1, аймгийн болон сумын Засаг даргын жуух бичгээр 3, сумын Засаг даргын талархалаар 2, аймгийн ахмадын холбоо, залуучуудын холбооны шагналаар 4 ахмад шагнагдсан. Мөн Дэлхийн багш нарын 23, Монголын багш нарын 51 дэх баярыг зохион байгуулж, боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа багш ажилчдыг шагнаан урамшуулсан.

Сумын эрүүл мэндийн төв 240 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 78, амбулаторын үзлэгт 42, идэвхитэй хяналтаар 39, гэрийн идэвхитэй үзлэгээр 81 үзлэгийг хийж, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж зөвлөгөө өгсөн. Дархлаажуулалтын аяныг “Томуугийн эсрэг дархлаажуулалт” уриан дор зохион байгуулж, 7, 15 настай 39 хүүхдийг сахуу татрангийн, 15 хүүхдийг улаан бурхан өвчний эсвэл вакцинд тус тус хамруулсан.

Нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олгож, өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны баталгаажуулалтыг ажлыг зохион байгуулж, нийт 256 өрхийг хамруулсан.

Сумын Ерөнхий боловсролын сургууль, 26-р цэцэрлэгийн багш нарын дунд “Багаараа хөгжилдье”, “80 чихрийн уналт”, “90х60х90”, “Та та тунга”, “Яг түүн шиг” шоу зэрэг тэмцээн уралдааныг зохион байгуулснаас гадна цэцэрлэгийн бэлтгэл хүүхдийн дунд бага насны хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх, авхаалж самбааг сорих зорилгоор “АХА” танин мэдэхүйн тэмцээнийг явууллаа.

Тайлант сард 40 иргэний бүртгэл хийгдсэнээс шинээр төрсөн 5, гэрлэлт бүртгүүлсэн 1, эцэг тогтоох бүртгэл 3, иргэний үнэмлэх гээгдүүлсэн 2, цахим үнэмлэх захиалсан 10, шилжин ирсэн 9, шилжин явсан 10 иргэн байна.

Орон даяар зохион байгуулагдсан цэрэг татлагын арга хэмжээнд сумын 76 цэргийн насны залуучуудад зарлан дуудах хуудас тарааж, 42 иргэн эмч нарын үзлэгт хамрагдаж, 4 иргэн цэргийн албанд тэнцсэн.

Түшиг сум:

Түшиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 8 дугаар хуралдаанаар Түшиг сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2018 оны сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэлэлцэн баталж, Хурлын 2017 оны 13 тоот тогтоолоор Ганцын даваа, Моностой зэрэг газруудыг нөөцийн хадлан бэлтгэх газраар тогтоож, хадлан бэлтгэхээр гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, иргэдээс орон нутгийн аюулгүй нөөцөд одоогийн байдлаар 1000 гаруй боодол өвс төвлөрүүлээд байна.

“Олон улсын ахмад баяр”-ын өдрийг Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Соёлын төв хамтран зохион байгуулж, нийт 65 ахмад настан оролцож, арга хэмжээний хүрээнд ахмадуудын дунд бүжгийн тэмцээн, гар бөмбөг, олс таталтын тэмцээн зохион явуулж байр эзэлсэн ахмадуудад мөнгөн урамшуулал гардууллаа.

10 дугаар сарын 06-ны өдөр “Багийн өдөрлөг” арга хэмжээг амжилттай зохион байгуулж, иргэдийн дунд хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн, мөн иргэдийн санал

хүсэлтийг дагуу нохой устгалын ажлыг зохион байгуулан сумын төвийн 23 золбин нохойг устгалаа.

2017 оны 2 дугаар ээлжийн цэргийн жинхэнэ албаны эрүүл мэндийн үзлэгт хамруулахаар цэргийн насны иргэдэд зарлан дуудах хуудас гардуулж иргэдийн 85%-ийг хамруулснаас цэргийн жинхэнэ албанд татагдахаар тэнцсэн иргэдийг цэргийн албанд үдэн гаргаж өгсөн.

Малчин болон мал бүхий өрхүүдээр орж өвөлжилтийн бэлтгэл ажлын судалгаа авахад иргэд өвс тэжээлээ бүрэн бэлтгэсэн байна. Сумын хэмжээнд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 1400 толгой тугал, 12400 толгой хурга, ишиг, нийт 13800 толгой мал хамрагдсан.

Аймгийн төвд зохион байгуулагдсан "Сэлэнгэ ногоон өдрүүд 2017" үзэсгэлэн худалдаанд ногоочид, өрхийн аж ахуй эрхлэгчид амжилттай оролцлоо. Тус үзэсгэлэн худалдаанд төмс хүнсний ногоо, мөөг жимсний чанамал, дарсан ногоо зэргийг борлуулж нийт 700'0 мян төгрөгний борлуулалтыг хийлээ.

2017 оны орон нутгийн орлого эхний 10 сарын 20-ны байдлаар төлөвлөгөө 89613,0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 68782,7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 76,7%-ийн биелэлттэй байна.

Газар өмчлөх тухай 18, газар эзэмших тухай 7, газар эзэмших эрхээ шилжүүлэх тухай 3, өмчлөгч хасуулах тухай 1 иргэний өргөдөл тус тус хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлийн гэрчилгээ авах анхан шатны материал бүрдүүлэлтэд зөвлөгөө өглөө. Газрын тухай хуулийн 52-р зүйлийн 52.7-р зүйлийн дагуу 3 иргэнд эзэмшиж буй газрын 2,34 га газрыг сумын Засаг даргын захирамжаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэв. Аймгийн газрын албанаас газар эзэмших 10 гэрчилгээ авч, газар эзэмших 5 иргэнд газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ, газар эзэмших эрхийг баталгаажуулсан 5 гэрчилгээ олгосон байна. Энэ сард 8 иргэний газрыг болон байшингийн кадастрын зургаар хангасан.

Монгол Улсын газрын төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 152-р тогтоолын дагуу "Редхил Монголия" ХХК-д газрын төлбөрийн 8.9 сая төгрөгийн газрын төлбөр ноогдуулж газрын төлбөрийн орлогыг бүрэн оруулсан байна.

Эрүүл мэндийн газрын дарга, мэргэжилтнүүд тус суманд ажиллаж сүрьеэ өвчний 1 сарын аян зохион байгуулах ажлын талаар заавар зөвлөгөөг өгсч, ЕББДС-ийн 46 сурагчид сахуу татран, улаан бурхан дархлаажуулалтын, 8-12 ангийн 98 сурагчдад БЗДХ, хүсээгүй жирэмслэлт сэдвээр сургалт хийлээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр бичил лабораторийн багаж хэрэгслийг хүлээн аваад байгаа бөгөөд зөгийн балыг шинжлэх багаж төхөөрөмжөөр орон нутгийн иргэдийн зөгийн бал, сүү цагаан идээ, хүнсний дэлгүүрүүдэд худалдаж байгаа махыг шинжилгээнд хамруулаад байна.

ЕББДС-ийн 2017-2018 оны хичээлийн жилд "STEAM" сургалт хичээллэж байгаа бөгөөд Улсын тэргүүний 4-р сургуулийн Цолмон багштай 10а ангийн 7 сурагч, Түшиг сумын ЕББДС-ийн М.Байгалмаа багштай 10а ангийн 5 сурагч "Сурагч солилцоо-2017" хөтөлбөрт хамрагдаж байна.

Тайлант хугацаанд шинээр төрсөн 2, гэр бүл цуцлалт 1, нас баралт 2, иргэний үнэмлэх олголт 7, иргэний үнэмлэх шинээр захиалсан 14, шилжин явсан 2, шилжин ирсэн 5 бүртгэгдсэн бөгөөд иргэдийн шилжилт хөдөлгөөн энэ сард эерэг хандлагатай байна.

Хушаат сум

Тайлант сард зөрчлийн тухай хууль, архины хор уршиг, хүүхдийн эрхийн тухай хууль, хуульд заагдсан малчдын үүрэг, малын удмын сан, тэтгэвэр, тэтгэмжийн тухай, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудаар гарын авлага бэлтгэн сурталчиллаа. Мөн "Хушаатын мэдээ" 3-р улирлын сонинг бэлтгэн айл өрхүүдээр тарааж суманд зохион байгуулагдсан арга хэмжээнүүдийн мэдээг сумын сайт болон фэйсбүүк хуудаст тавьж иргэд, байгууллагыг мэдээллээр хангаж байна.

Нэрт зохиолч Д. Сэнгээгийн 100 насны ой, ЕБСургууль байгуулагдсаны 30 жилийн ойн арга хэмжээ 10-р сарын 07-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Сургуулийн удирдлага болон багш ажиллагсад төрөлх сургуулийнхаа ойг угтан 17 чиглэлийн 74 төрлийн ажлыг зохион байгуулахаар төлөвлөж сургуулийн гадна талбай, сургалтын таатай орчин бүрдүүлэх, зочид төлөөлөгч, төгсөгчдийг хүлээн авах ажлуудыг хийлээ. Тус үйл ажиллагаанд ардын уран зохиолч Б.Бааст, Х.Зандраабайдий, хүүхдийн зохиолч Энхбаяр, МУГДуучин Мөнхшүр, Нутгийн зөвлөлийн Занданхүү, зохиолч Д.Сэнгээгийн хүү С.Эрдэнэбилэг нар хүрэлцэн ирж нэрт зохиолчийн хөшөөний нээлтийн үйл ажиллагаанд үг хэлж, Төрийн соёрхолт дуурийн дуучин Мөнхшүр түүний зохиосон "Тагтаа" дууг дуулж хүндэтгэл үзүүллээ. Мөн их зохиолч, төрийн хошой соёрхолт Дашзэвэгийн Сэнгээгийн төрсөн гэрийн буурь Дулаан уулын ар дээр их зохиолчид хүндэтгэл үзүүлж дурсгалын хөшөө босголоо. Энэ арга хэмжээнд сумын удирдлагууд, Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн гишүүд, түүний үр хүүхдүүд оролцлоо.

"Хүүхдийн эрх оролцоо, хөгжил хамгаалал" хүүхдийн 2-р чуулганыг зохион байгуулж, " Хөрсний зүсэлт, үе давхарга тодорхойлох" "Орон нутгийн нийгэм эдийн засгийн мэдээлэл", "Хөрсний РН , чийглэг хэмжих", "Орон нутгийн ой, ургамал", Хөрсний элэгдэл, гүний температур" , "Орон нутгийн уур амьсгалын өөрчлөлд өртөх байдал", "Амьтны индекс тодорхойлох", "Орон нутгийн гол, ус тусгай хамгаалалтай газар нутаг, амьтан","Ургамлын индекс тодорхойлох", "Орон нутгийн цөлжилтийн газар зүйн мэдээлэл", "Хүүхдийн эрх оролцоо, хөгжил хамгаалал"- сэдэвт сургалтуудыг мэргэжлийн багш нар оролцож, сумын байгаль хамгаалагч, газрын даамал нар зөвлөхөөр ажиллалаа.

Бага ангийн "Үдийн цай хөтөлбөр"-т нийт 165 хүүхэд хамрагдаж халуун хоол, цайгаар үйлчлүүлж байна. Бага ангийн сурагчдыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулж, эмчилгээ хийлгэх шаардлагатай хүүхдэд эрүүл мэндийн зөвлөгөө өгч эцэг эхэд нь мэдэгдлээ.

Цэцэрлэгийн хүүхдүүдийг өдөр бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулан өсөлт хөгжлийн судалгааг авч бүлгүүдийн эмийн сангуудад үзлэг хийн яаралтай байх эмийн тусламжийг бүрдүүлэн зөвлөгөө өгч байна. Энэ сард ханиад томуунаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Витаминжуулалт" сарын аянг зохион байгуулсан.

Сумын Соёлын төвөөс Ахмадын баяраар ахмадуудад хүндэтгэл үзүүлж урлагийн тоглолт, дуун цэнгүүн үдэшлэг, Кофет уншлагыг зохион байгууллаа. УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат номын санд 35 ном хандивлалаа.

Эрүүл мэндийн төвд 23 иргэн хэвтэн эмчилүүлж, нийт 176 иргэнд үзлэг хийж, урьдчилан сэргийлэх тарилгад 100 хүүхдийг хамруулсан.

Сумын хэмжээгээр энэ сард 1 гэмт хэрэг гарч хэсгийн цагдаа, багийн Засаг дарга нар гаднаас зөвшөөрөлгүй ирж буусан 8 өрхөд нүүх мэдэгдэл өглөө. Хэв журмын цагдаа нь энэ сард эргүүлд 12 удаа гарч 86 цагийн үүрэг гүйцэтгэн АСТТХууль зөрчин биеэ авч явах чадваргүй явсан 4 хүнийг ар гэрт нь хүлээлгэн өгч энгийн харуул манааг давхардсан тоогоор 25-ийг шалган ээлжинд гарч буй жижүүрүүдийг сонор сэрэмжтэй байхыг анхааруулан гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй 2 иргэнтэй биечлэн уулзаж эрх зүйн зөвлөгөө өгчээ.

Энэ сард улсын бүртгэлийн үйлчилгээгээр төрөлт 2, овог нэр өөрчлөлт 3, эцэг тогтоолт 1, шилжин явсны 7, шилжин ирсний 6, цахим үнэмлэх дахин авах 5, биеийн давхцахгүй өгөгдлийн 26, газар өмчлөх эрхийн 2, иргэний үнэмлэх олголтын 8 нийт 61 бүртгэл хийж 8 гэрчилгээ бичиж олгосон. Төрийн сан банкны орон нутгийн дансанд 106000, УБСГ-ын дансанд 489000 төгрөгийн орлого оруулсан байна.

Төсөв санхүүгийн хувьд батлагдсан хуваарийн дагуу орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө нь 10-р сарын байдлаар 228646.8 мянган төгрөг, олгосон санхүүжилт 228646.8 мянган төгрөг олгон 100% олгосон байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь 93.7%-тай явж байгаа ба аймгаас авах тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын санхүүжилт 748299.8 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэл 100% байна. Өөрийн орлогын төлөвлөгөө 6722.0 мянган

төгрөг, гүйцэтгэл нь 6892.0 мянган төгрөг 102.5%-ийн гүйцэтгэлтэй байна. Сумын хэмжээгээр нийт 976946.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Сумын хэмжээнд энэ онд үр тариа 12228 га тариалснаас 1091 га ургац алдаж тэжээлд шилжсэн. 11137 га-гаас 18175.0 тн буюу 1 га-гаас 16,3 цн үүнээс улаанбуудай 11107 га-гаас 18139.0 тн /16,3 цн/, овьёос 30 га-гаас 36.0 тн буюу 12,0 цн/га. Рапс 3419 га тариалснаас 1064 га ургац алдаж тэжээлд шилжин 2355 га-гаас 1279.0 тн буюу 5,4 цн/га ургац хураан авсан. Тэжээлийн ургамал 30 га тариалж 10 га ургац алдан тэжээлд шилжиж 20 га-гаас 10.0 тн буюу 5.0 цн/га ургац хураан авсан. Төмс 246 га тариалснаас 7 га төмс хөлдөж 239 га-гаас 3139.0 тн буюу 131.3 цн/ га хураан авлаа. Хүнсний ногоо 182.6 га тариалж 182.6 га-гаас 2506.5 тн буюу 1 га-гаас 137.3 цн/га ургац хураан авсан. 4461 га уринш бэлдсэнээс 2337 га химийн, 2124 га механик уринш бэлдсэн. байгалийн хадлан 8300.0 тн бэлдэж 5200.0 тн-ыг зах зээлд, 3100.0 тн-ыг малчдын хэрэгцээнд бэлдсэн. Гурилын үйлдвэрүүдэд улаанбуудай тушаах ажил, үр нөөцлөх ажил 70-80%-тай явагдаж байна.

Аймгийн "Ногоочдын зөвлөгөөн-2017" ногоочдын үзэсгэлэн худалдаанд 4 иргэн оролцож "Аймгийн хүнсний ногоо хөтөлбөр"-ийг хэлэлцэхэд оролцон ногооны үзэсгэлэн худалдаанд 5 төрлийн төмс, хүнсний ногоо, 6 төрлийн даршилсан ногоо, 2 төрлийн жимсний чанамалаар оролцлоо.

Энэ жил сумын хэмжээнд бог малын хуц 92, ухна 108 хээлтүүлэгчийг бруцеллёзын шинжилгээнд хамруулан нийт хээлтүүлэгч бруцеллёз өвчнөөр эрүүл болох нь тогтоогдож бог малын хээлтүүлгийн ажлыг эхлүүлж хээлтүүлэгчийг эзэд нь хүлээлгэн өгөх ажлыг 10 сарын 1-10 хооронд зохион байгууллаа.

Сумын хэмжээнд бруцеллёзын вакцинжуулах арга хэмжээнд давхардсан тоогоор 218 малчин, мал бүхий өрхийн 1596 тугал, 22857 хурга, ишиг хамрагдлаа Арьс ширний урамшуулалд хамрагдахаар материалаа ирүүлсэн 106 малчин, мал бүхий өрхийн РД, дансны дугаарын тулгалтын ажлыг хийж дээд байгууллагад хүргүүлээ.

Тайлант сард байгаль орчны албанаас дэрвэгэр жиргэрүү түүх "Алтайн ойл" ХХК-тай гэрээ хийн орон нутгийн орлогод 5000000 төгрөг оруулж багийн дарга нар, эмч нар, байгаль хамгаалагч нарын бүрэлдхүүнтэйгээр иргэдэд модны эрхийн бичиг хийж өгөх, мод бэлтгээгүй өрхүүдэд сануулж анхааруулах ажлыг хийлээ.

Иргэдийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 23 иргэнд улиас 80 м3, хус 13 м3, нарс 4 м3, шинэс 16 м3, нийт 113 м3 модны эрхийн бичиг олгож, 203730 төгрөгийн орлого оруулсан.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР